# ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНД УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ЭРХЛЭХ АСУУДЛААР ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

2020 оны 6 дугаар сар 22

## Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд салбарын асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийг тухайн жилд тавьсан зорилтыг хүрэх түвшинтэй нь харьцуулан, хэрэгжилтийн түвшинг тогтоох, үр дүнг үнэлэх, зөвлөмж, дүгнэлт гаргах, яамны удирдлагыг бодит мэдээллээр хангах, цаашид төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

## Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй.

Хяналтад авсан зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд яамны эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн 2020 оны хагас жилийн тайлан, бодлогын газруудын үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд үндэслэн гүйцэтгэв.

Төлөвлөсөн арга хэмжээ бүрийг хэрэгжүүлэх хугацаанд хийсэн ажлын гүйцэтгэлийг тухайн /2020/ оны хүрэх түвшинтэй харьцуулан биелэлтийг хувиар тодорхойлж үнэлгээг гаргав.

## Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн.

Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан нийт 36 зорилтын 105 арга хэмжээ, үүнээс 76 арга хэмжээг толгойлон, 28 арга хэмжээг хамтран, 1 арга хэмжээг оролцогчоор хэрэгжүүлэхээр тусгагдсаныг хяналтанд авч сайдын 2017 оны А/22 дугаар тушаалаар батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллав.

2020 оны хагас жилийн үнэлгээг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн /unelgee.gov.mn/ цахим системд байршуулсан 27 зорилтын 74 арга хэмжээний хүрээнд хийлээ.

Хяналтанд авагдсан 74 арга хэмжээний 55 арга хэмжээг яам толгойлон, 18 арга хэмжээг хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан ба толгойлон хэрэгжүүлсэн нийт 74 арга хэмжээний биелэлт 86.4%-тай дүгнэлээ.

Арга хэмжээнүүдийн биелэлтийг бодлогын зорилтоор нь авч үзвэл:

- Эдийн засгийн хүндрэлийг даван туулах онцгой бодлогын хүрээний 1 зорилтын 3 арга хэмжээний биелэлт 70,0 хувь,
- Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлогын хүрээний 22 зорилтын 63 арга хэмжээний биелэлт 85,7 хувь,
- Нийгмийн бодлогын хүрээний 1 зорилтын 1 арга хэмжээний биелэлтэд үнэлгээ өгөөгүй, /-/
- Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлогын 3 зорилтын 7 арга хэмжээний биелэлт 100 хувь, хэрэгжүүлсэн нийт 74 арга хэмжээний биелэлтийг 86.4 хувьтай дүгнэлээ.

ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЯВЦЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТОВЧОО

/2020 оны хагас жил/

| **Зорилт** | **Зорилтын тоо** | **Арга хэмжээний тоо** | **Хэрэгжилтийн хувь, арга хэмжээний тоо** | | | | | **Хэрэгжилт /хувь/** |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100 | 70 | 40 | 0 | /-/ | |
| Нэг. Эдийн засгийн хүндрэлийг даван туулах онцгой бодлого | 1 | 3 | 1 | 1 | 1 | | | 70,0 |
| Хоёр. Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлого | 22 | 63 | 39 | 15 | 7 | - | 2 | 85.7 |
| Гурав. Нийгмийн бодлого | 1 | 1 | | | | | 1 | /-/ |
| Дөрөв. Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлого | 3 | 7 | 7 | | | | | 100 |
| **Дүн** | **27** | **74** | **47** | **16** | **8** | **-** | **3** | **86.4** |

**2020 оны хагас жилийн байдлаар хэрэгжилт хангалтгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай 8 арга хэмжээ байна *I40%-ийн биелэлттэйI*.**

- *1.24.3. Цагаан суварга төслийг хэрэгжүүлэх*
- *2.59.3. Монгол Улсын баруун өмнөд хэсгийг хамарсан талбайд агаарын геофизикийн цогцолбор судалгааны ажлыг хэрэгжүүлэх,*
- *2.71.3 Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих, ашиглалтанд оруулах*
- *2.72.3 Төмөртэйн уурхайд хуурай болон нойтон соронзон баяжуулах үйлдвэр байгуулах*
- *2.72.4 Шууд ангижруулсан төмрийн үйлдвэр байгуулах*
- *2.72.5 Гангийн үйлдвэрийн өргөтгөл хийж, хүчин чадлыг нь нэмэгдүүлэх*
- *2.73.5 Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэрийн нарийвчилсан ТЭЗҮ, барилгын зураг төсөл боловсруулах, барилгын ажлыг гүйцэтгэж, үйлдвэрийг хүлээн авч ашиглалтад оруулах*
- *2.74.1 Улаанбаатар хотод жилд 15,000 тн тос, тосолгооны материал үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр байгуулахыг дэмжих*

Мөн 3 арга хэмжээний биелэлтэд үнэлгээ өгөх боломгүй бөгөөд эдгээр арга хэмжээнүүд нь Цөмийн энергийн комиссын ажлын алба /ЦЭК/, Барилга хот байгуулалтын яам /БХБЯ/, Эрчим хүчний яам /ЭХЯ/, Үндэсний хөгжлийн газар /ҮХГ/ тус тус толгойлон хэрэгжүүлэх ажиллаж байна.

**Үнэлэх боломжгүй 3 арга хэмжээ**:

- *2.92.2 Хөрсний усыг үйлдвэрийн технологийн хэрэгцээнд ашиглах чиглэлээр судалгаа хийх /БХБЯ, ШУТИС/*
- *2.99.3 Хашаат цав, Тэвшийн говийн орд газруудыг түшиглэн том чадлын цахилгаан станц, тогтмол гүйдлийн цахилгаан дамжуулах шугам, нүүрсний уурхай байгуулах төслүүдийг эхлүүлэх /ЭХЯ, ҮХГ/*
- *3.2.33.10 Уул уурхай, шинжлэх ухааны чиглэлд бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх хүрээнд Шинжлэх ухаан, танин мэдэхүйн мэдээллийн төв байгуулах барилга, байгууламжийн асуудлыг шийдвэрлэх /ЦЭКАА/*

**Дөрөв. Дүгнэлт**.

1. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний гүйцэтгэл 2020 оны хагас жилийн байдлаар 86.4 хувьтай дүгнэснээс 47 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, 16 арга хэмжээ 70 хувь, 8 арга хэмжээ 40 хувийн тус тус хэрэгжилттэй, тасарсан арга хэмжээ байхгүй.
2. Эрчим хүчний яам, Барилга хот байгуулалтын яам, Цөмийн энергийн комиссын ажлын алба зэрэг бусад байгууллагын толгойлон хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээнүүдийн биелэлтэд үнэлгээ хийх боломжгүй байна.
3. Цаашид урт хугацаанд хэрэгжих арга томоохон зорилт, хэмжээнүүдийн төлөвлөлтийг бодитой, хэрэгжүүлэх үе шатуудыг тодорхой зааж төлөвлөх шаардлагатай байна.
4. Бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээний биелэлт гаргахад бэрхшээлтэй, хамтран ажиллах талаар толгойлон хэрэгжүүлэгч байгууллагаас ханддаггүй байдал давтагдсаар байна.

**Тав. Санал, зөвлөмж.**

1. Төрийн байгууллагуудын хамтран хэрэгжүүлэгчээр тусгагдсан зорилт, арга хэмжээг толгойлон хэрэгжүүлэх байгууллага хяналтад авч, хамтран хэрэгүүлэх байгууллагатай ажлын уялдааг хангадаг байх талаар арга хэмжээ авах шаардлагатай.
2. Яамны дотоод нэгжүүд, хэрэгжүүлэгч агентлаг хэрэгжилт удаашралтай 8 арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн хангах, зорилтот түвшинд хүргэх, дараагийн засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт үргэлжүүлэн, зорилтот арга хэмжээний гүйцэтгэлийг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах, удирдлага зохион байгуулалт, ажлын уялдааг сайжруулах нь зүйтэй,
3. Салбарын хэтийн болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан, тооцоо судалгаа, дүн шинжилгээний үндсэн дээр үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах, үүнд үндэслэн биелэлтийг тайлагнах шаардлагатай байна.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтэд 2020 оны хагас жил буюу эцсийн үнэлгээний тайланг хавсаргав.

Хянасан:
ХШҮДАГ-ын дарга Г.Ганхүү

Шинжээч Б.Баяржаргал

Үнэлгээ хийж дүгнэлт зөвлөмж гаргасан:

Мэргэжилтэн Д.Батнайрамдал

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

2020 оны 06 дугаар сар 22

Засгийн газрын Үйл ажиллагааны хөтөлбөр

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

2020 оны хагас жил

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Үндсэн хэрэгжүүлэх байгууллага | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | 2019 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ ОНЦГОЙ БОДЛОГО | | | | | | | | |
| 1 | 1.24.“Эрдэнэс Монгол” компани болон Оюутолгой төслийн үйл ажиллагааг эрчимжүүлж, Тавантолгой, стратегийн ач холбогдол бүхий бусад ордыг эдийн засгийн эргэлтэд оруулна. | 2. Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх | 2016 - 2020 | УУХҮЯ /ГУУБХЗГ/ | 2,600,000.00 | Далд уурхайн ажлын гүйцэтгэл 45 хувь | "Оюу толгойн зэс алтны ордыг ашиглах далд уурхайн бүтээн байгуулалтад 2018 онд 1,076.3 сая ам.доллар оруулахаар төлөвлөж, далд уурхайн хэвтээ малталтыг 11159 метр нэвтрэхээр төлөвлөснөөс 9555 метр, конвейерын налуу аманд 3474 метр нэвтрэлт хийхээс 2732 метр малталт нэвтэрч, 5 дугаар босоо амны нэвтрэлт 56 метр нэвтрэхээс 56 метр гүнзгийрсэн байна. Далд уурхайн бүтээн байгуулалтаас гадна ил уурхай, баяжуулах үйлдвэр ажиллаж байна. 2018 онд ил уурхайгаас 43328 мян.тонн хүдэр олборлож, Баяжуулах үйлдвэрт 582.6 мян.тонн зэсийн баяжмал үйлдвэрлэхээр төлөвлөснөөс үйлдвэрлэл, экспорт хэвийн явагдсан байна. Далд уурхайн ажлын гүйцэтгэл 2018 оны жилийн эцсийн байдлаар 46.2% байсан бол 2019.12.31-ний өдрийн байдлаар 64%-тай байна. Үүнд:<br>-далд уурхайн бүтээн байгуулалтын үйлдвэрлэлийн 2 дугаар босоо амыг барьж дуусгаж ашиглалтад оруулсан.<br>-далд уурхайн хөндлөн малталт -30,923 экв.м3,<br>-налуу буюу конвейрийн малталт -8.299 экв.м3,<br>-босоо ам 3-нэвтрэлтийн тоног төхөөрөмжийг суурилуулах ажил хийгдэж байна. Босоо ам 4 -нэвтрэлтийн цамхаг барих  ажил явагдаж байна. 2019 оны нийт хөрөнгө оруулалт - 1,125,207,793 ам.доллар.<br>Далд уурхайн бүтээн байгуулалтын нь Ковид-19 цар тахалтай холбогдуулан зорчигч болон ачаа тээврийн улс доторх болон хил дамнасан хөдөлгөөнийг хязгаарласан нөхцөл байдал байдлаас үүдэн Агааржуулалтын 3, 4 дүгээр ам болон бусад малталтуудын ажлыг зогсоож арчилгаа, тордлогыг тогтмол хийж байна.<br>2020 оны эхний хагас жилийн байдлаар далд уурхайн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл нийтдээ 70 хувьтай байна.<br>-Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.12 дахь заалтыг үндэслэн стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын талбайн хил, заагийг тогтоох талаар санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг нь 2019.02.21, 2019.03.06-ны өдрүүдэд хуралдаж Асгатын мөнгөний, Оюу толгойн зэсийн, Төмөртэй төмрийн, Төмөртэй Овооны цайр, хар тугалганы, Мардай, Дорнод, Гурванбулагын ураны ордуудын геологи, ашигт малтмалын зургуудыг бэлтгэсэн. Эхний ээлжид Оюу толгой, Асгат, Төмөртэй Овооны ордуудын талбайн хил, заагийг урьдчилсан байдлаар тогтоох зорилгоор тус ордуудын ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тавантолгойн ордыг иж бүрэн ашиглах төслийг боловсруулж, хэрэгжүүлэх | 2017 | УУХҮЯ /ГУУБХЗГ/ | | | “Эрдэнэс-Тавантолгой” ХК нь 2019 онд 18 сая тонн нүүрс олборлохоор төлөвлөснөөс 16.2 сая тонн нүүрс олборлосон нь өмнөх онтой харьцуулахад 46%-иар өссөн байна. Тус компани 2019 онд 14.95 сая тонн нүүрс борлуулахаар төлөвснөөс 15.5 сая тонн нүүрс борлуулсан нь өмнөх онтой харьцуулахад 18%-иар өссөн байна.<br>2019 онд нүүрс борлуулалтаас 1.0 тэрбум доллар буюу 2.66 их наяд төгрөгийн орлого олсон нь 2018 онд 1,986.9 их наяд төгрөгний борлуулалтын орлого олж байснаас 34%-иар өссөн байна. Тус компани 2019 онд 1 их наяд төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь 2018 онд 807.6 тэрбум төгрөгний цэвэр ашигтай ажиллаж байснаас 28%-иар өссөн байна. Тус компани 2019 онд улс, орон нутгийн төсөвт 736.1 тэрбум төгрөгийн татвар, хураамж төвлөрүүлсэн нь 2018 онд 478.8 тэрбум төгрөг төвлөрүүлж байснаас 1.5 дахин өссөн байна. | 100 |
| 2 | | 3. Цагаан суварга төслийг хэрэгжүүлэх | 2016 - 2020 | УУХҮЯ /ГУУБХЗГ/ | | Уулын баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах | Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл /ЭБМЗ/-ийн хурлаар Цагаан суварга ордын зэсийн исэлдсэн хүдрийн нөөцийн тодотгол, жилд 5000 тонн катодын зэс үйлдвэрлэх үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийг хэлэлцэж хүлээн авсан. Ордын геологи хайгуулын ажлыг баруун нэр хүнд бүхий компаниудтай хамтран Канадын CIM 43-101, Австралийн JORC стандартын дагуу гүйцэтгэн, баялаг болон нөөцийг тооцож үнэлэн, 250 сая тонн хүдэр буюу 1.6 сая тонн зэсийн нөөцийг Ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд 2009 онд бүртгүүлсэн. Тус нөөцийг түшиглэн уулын баяжуулах үйлдвэр барих урьдчилсан болон банкны ТЭЗҮ-ийг гадаад дотоодын шилдэг компаниудтай хамтран боловсруулж Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2013 онд хэлэлцүүлэн батлуулсан ба тус ТЭЗҮ-ийн тодотголыг боловсруулж Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн А/109 дүгээр тушаалаар шинжээчийн баг дүгнэлт гаргахаар ажилласан.<br>Үйлдвэрийн зураг төслийн ажлыг гүйцэтгүүлж, үндсэн тоног төхөөрөмжийг нийлүүлэх гэрээг 2011 онд АНУ-ын FLSmidth компанитай байгуулан хамтран ажиллаж байна. Одоогоор нарийвчилсан зураг төслийн ажлын гүйцэтгэл 85%, үндсэн тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл 95%-тай байгаа бөгөөд Америк болон Европын орнуудад хадгалагдаж байгаа үйлдвэрлэгдэж дууссан тоног төхөөрөмжүүдийг төслийн талбай руу тээвэрлэж эхлээд байна. Үйлдвэрийн барилга угсралтын ажлыг FLSmidth компанийн удирдлаган дор БНХАУ-ын Hengyuan International компани гүйцэтгэж байна. Одоогоор газар шорооны ажил бүрэн дууссан, анхан шатны бутлуурын хүчитгэсэн хана угсралтын ажил 50%-тай, үйлдвэрийн барилгын суурьнд 20,000 м3 бетон цутгаснаар 33%-ийн гүйцэтгэлтэй, зарим барилгын төмөр хийцийн угсралтын ажлыг гүйцэтгэсэн бөгөөд нийт барилга угсралтын ажлын явц 25.9%-д хүрсэн байна.<br>Ирээдүйд уулын баяжуулах үйлдвэрийг ажиллуулахад 73МВт чадал шаардагдах бөгөөд одоогоор эрчим хүчний хэрэглээ байхгүй байгаа хэдий ч хөрш зэргэлдээх Мандах болон Хатанбулаг сумдыг эрчим хүчний сүлжээнд холбох хэрэгцээ шаардлага байгааг харгалзан үзэж Цагаансуварга-Оюутолгой чиглэлийн давхар хэлхээт 160 км урт 220КВ-ын ЦДАШ, 220/22 кВ-ын дэд станцын зураг төсөл, барилга угсралтын ажлыг үндсэний компаниудаар гүйцэтгүүлж 2017 онд ашиглалтанд оруулсан. Одоогоор Цагаансуварга 220/22 кВ-ын дэд станцын 220кВ-ын 10 МВА-ын чадалтай | 40 |

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ БОДЛОГО

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | 2.11.Чөлөөт бүсүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжиж ажиллана. | 3. Замын-Үүд чөлөөт бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, улмаар Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төслийн хоёрдугаар ээлжийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх | 2017 - 2020 | БХБЯ | | Чөлөөт бүсийн хот төлөвлөлтийн баримт бичигтэй болох, дэд бүтцийн 2 дугаар ээлжийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэх | 2017 оны 05 сарын 12-15-ны өдрүүдэд БНХАУ-д зохион байгуулагдсан "Бүс ба Зам" уулзалтанд МУ-ын ерөнхий сайд оролцохтой холбогдуулан айлчлалын удирдамж, хэлэлцээрийн сэдэвт Замын-Үүд чөлөөт бүсийн 200 га-д үйлдвэрлэлийн парк байгуулах төслийн талаар тусгуулах саналыг ГХЯ-нд хүргүүлсэн. Монгол Улсын хүнд үйлдвэржилтийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөлтийг хөрш орнуудын үйлдвэржилт, хөгжлийн чиг хандлагатай уялдуулах чиглэлээр 2018.04.01-07-нд холбогдох ажилтнууд БНХАУ-ын зарим хилийн боомтын ойролцоох хүнд үйлдвэрлэл, аж үйлдвэрийн паркийн үйл ажиллагаатай танилцав. Энэхүү ажлын хүрээнд БНХАУ-ын ӨМӨЗО-ны хүнд үйлдвэр, аж үйлдвэрийн паркийн үйл ажиллагаатай танилцаж, холбогдох санал, дүгнэлтийг боловсруулж, 2018.05.16-нд Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн.<br>"Замын-Үүд" чөлөөт бүс дээр 2019.04.30-ны өдөр төр-хувийн хэвшлийн уулзалт, семинар зохион байгуулагдаж, "Замын-Үүд" чөлөөт бүсийг 2019 онд байнгын үйл ажиллагаанд оруулах бэлтгэл ажлын хүрээнд төр, хувийн хэвшлийн үйл ажиллагааг жигдрүүлэх, чөлөөт бүсийг хөгжүүлэх төрийн бодлого шийдвэрийг танилцуулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөмж өгөх холбогдох аж ахуй нэгж, байгууллагын 50 гаруй төлөөлөл оролцож, харилцан мэдээлэл, санал солилцсон.<br>Биелэлт 90% | 70 |
| 4 | 2.17.Шатахууны үнийг дэлхийн зах зээлийн үнэтэй уялдуулан үнийн дарамтыг бууруулна. | 1. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийг шинэчлэн найруулах | 2017 - 2018 | УУХҮЯ /ХҮГТБХЗГ/ | | Холбогдох байгууллагуудтай хамтарсан ажлын хэсэг байгуулж, хуульд өөрчлөлт оруулах | Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах ажлын хүрээнд ХЗДХС/УУХҮС-ын 2017.12.13-ны өдрийн хамтарсан А/298/А/240 тоот тушаалаар батлагдсан ажлын хэсгийг байгуулан ажиллаж "Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль"-ийн нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулж, "Газрын тосны бүтээгдэхүүний тухай" хуулийн төслийг боловсруулж ЗГ-ын 2018 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж дэмжигдсэн. Дээрх ажлын хэсгийн хүрээнд уг хуулийн давхардал хийдэл, зөрчлийг арилгах замаар шинэчлэн найруулахгүйгээр нэмэлт өөрчлөлтүүдийг хийв. Мөн 2018.10.24-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар Ашигт малтмалын тухай, Газрын тосны тухай, Газрын тосны бүтээгдэхүүний тухай болон бусад хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцээд УИХ-д өргөн мэдүүлж УИХ-ын 2019.05.26-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлсэн болович гишүүдийн олонхийн саналаар хуулийн төсөл буцаагдсан. Энэхүү хуулийн төсөл, үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд дахин ЗГ-ын хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцүүлэхээр ажиллаж байна. Биелэлт 100% | 100 |
| 5 | | 2. Газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний нөхцөлийг сайжруулах, шатахууны үнийг олон улсын биржийн үнэтэй уялдуулан зохицуулах | 2019 | УУХҮЯ /ХҮГТБХЗГ/ | | Хамтарсан ажлын хэсэг байгуулж, газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний нөхцөлийг сайжруулах | 2019.02.19-21-ний өдрүүдэд УУХҮЯ, АМГТГ-ын төлөөлөл оролцсон ажлын хэсгийн бүрэлдэхүүн ОХУ-ын Москва хотноо албан айлчлал хийж ОХУ-ын "Роснефть" компанийн төлөөлөлтэй уулзалт зохион байгуулсан. Уг уулзалтаар газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний зарим нэг заалтыг худалдан авагч талд нааштайгаар шийдвэрлэх талаар санал солилцсон. Уулзалтын үр дүнд гэрээний нөхцөлд тодорхой өөрчлөлтийг оруулж чадсан тухайлбал шатахууны төлбөрийн баталгааны хугацааг дараа сарын 15-ны дотор гэснийг дараа сарын 30-ны дотор гэж, мөн шатахууныг ямар нэг банкны баталгаа шаардахгүйгээр 45 хүртэлх хоногийн дараа төлбөрт нөхцөлөөр нийлүүлдэг байсныг 60 хүртэлх хоног болгон сунгасан. Түүнчлэн вагон зогсолтыг түргэсгэхийн тулд вагоны бичиг баримтыг "Роснефть" компанийн охин компани "Роснефть-Монголия" ХХК руу цахим шуудангаар явуулж хугацаа хэмнэдэг болсон . | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | 3. Алслагдсан бүс нутгийн шатахууны үнийг төвийн бүстэй ойролцоо түвшинд барих бодлогыг баримтлах | 2016 - 2020 | УУХҮЯ /ХҮГТБХЗГ/ | | Газрын тосны бүтээгдэхүүний хил үнэ, валютын ханшийн өөрчлөлт болон бусад холбогдох зардалтай уялдуулан шатахууны жижиглэн борлуулж буй үнийн зохицуулалтыг хийх | Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын “Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагаа”-ны 22 дугээр хуралдаан, “Бүс нутгийн болон хил орчмын хамтын ажиллагааны комисс”-ын 14 дүгээр хуралдааны протоколыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Монгол, Оросын хилийн хоёр талын зорчигч, ачаа тээврийн автомашины Арцсуурь-Цагаан толгой боомтоор газрын тосны бүтээгдэхүүн тээвэрлэх боломжийг судлах саналыг тусгуулан ОХУ-ын холбогдох байгууллагуудад хүргүүлэх саналыг тусгуулсан.<br>Мөн тус боомтоор газрын тосны бүтээгдэхүүн нэвтрүүлэх тусгай шугам гаргуулах, гаалийн бүрдүүлэлтийн цагийн хуваарийг сунгах талаар албан хүсэлтийг хүргүүлсэн. Гашуун сухайтын боомтоор автотээврийн хэрэгслээр шатахуун импортлох гарцыг бий болгох талаар судлан БНХАУ-ын талтай тохиролцсоны дүнд Хөх хотын боловсруулах үйлдвэрээс Евро-5 стандартын шатахуун импортлох туршилтын тээврийг М-Ойл ХХК эхлүүлэхээр бэлтгэл ажлыг хангаад байна.<br>Шатахууны хангамж, үнэ, нөөцийн өнөөгийн байдлын талаарх асуудлыг 2019.05.17-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулж, 22 дугаар тэмдэглэл гарсан.<br>Монгол Улсын Засгийн Газрын 2018.02.23-ны өдрийн 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Газрын тосны бүтээгдэхүүний хангамж, үнийг тогтворжуулах асуудлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын хамтарсан зөвлөл”-ийн IV хуралдааныг 2019.06.04-ний өдөр зохион байгуулсан ба уг хурлаас УУХҮЯ, АМГТГ, ШӨХТГ-т шатахууны хангамжийн олон талт эх үүсвэрийг нэмэгдүүлэх, алслагдсан бүс нутгийн шатахууны хангамжийг сайжруулах үүднээс бусад улсаас шатахуун импортлох боломжийг судлах, СЯ, УУХҮЯ, АМГТГ-т Олон Улсын Валютын сангаас хэрэгжүүлж буй хөтөлбөрийн хүрээнд “Дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ, импортын үнэ болон бусад хүчин зүйлсээс хамааран шатахууны жижиглэнгийн үнэ автоматаар тогтоох механизм”-ыг олон улсын болон дотоодын зөвлөхүүдтэй хамтран судлах, шатахууны худалдаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдэд Дэлхийн зах зээл дэх газрын тос болон хилийн үнэ, валютын ханшийн өөрчлөлт ороогүй тохиолдолд шатахууны жижиглэнгийн үнэд үндэслэлгүйгээр өөрчлөлт оруулахгүй байх тухай зөвлөмж гаргасан.<br>Дээрх зөвлөмжийн холбогдох заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах тухай 2019.11.13-ны өдрийн 07/3164 тоот албан бичгийг шатахуун импортлогч, борлуулагч нэр бүхий аж ахуйн нэгжүүд болон мэргэжлийн холбоодод хүргүүлэв. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | 4. Улсын болон компанийн нөөцийг бүрдүүлэх | 2018 | УУХҮЯ /ХҮГТБХЗГ/ | | Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 13.1-ийг хангах | 1. Засгийн газрын 2012.11.27-ны өдрийн 126 дугаар тогтоолоор батлагдсан "Газрын тосны бүтээгдэхүүн импортоор оруулж, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхэлж байгаа компанийн нөөц бүрдүүлэх журам"-ын 7 дугаар заалтын дагуу "Газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөцийн хэмжээг шинэчлэх тухай" ЗГ-ын тогтоолын төсөл болон 2019 онд газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөц бүрдүүлэх аж ахуйн нэгжүүдийн нэрсийн жагсаалт, бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ, танилцуулгын боловсруулж, 2018.10.24-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн 322 дугаар тогтоолоор батлуулсан. Тогтоолын хэрэгжилтийг хангах, жагсаалтад хамрагдсан аж ахуйн нэгжүүдтэй компанийн нөөц бүрдүүлэх гэрээ байгуулж, бүрдүүлэлтэд хяналт тавьж ажиллах чиглэлийг АМГТГ-т өгсөн. АМГТГ нь газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөл эзэмшигч 26 аж ахуйн нэгжтэй 116,5 мянган тонн компанийн нөөц бүрдүүлэх талаар гэрээг 2019.01.29-ний өдөр байгуулсан ба нөөцийн бүрдүүлэлтэд хяналт тавин ажиллаж байна.<br>Нэр бүхий аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан Улсын нөөцийн шатахууныг сэлгэн хадгалах гэрээний хугацаа дуусаж байгаатай холбогдуулан сэлгэн хадгалах гэрээг сунгахдаа улсын нөөцийн шатахууны хэмжээг тухайн аж ахуйн нэгжийн бүрдүүлэх компанийн нөөц, өөрийн эзэмшлийн агуулахын хүчин чадалтай уялдуулан шинэчлэх, шилжүүлэх арга хэмжээ авч, холбогдох хууль, журамд нийцүүлэн гэрээ байгуулах ажлыг зохион байгуулахыг 2019.04.30-ны өдрийн 03/1248 тоот албан бичгээр чиглэл болгосон.<br>Мөн 2020 онд газрын тосны бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх компанийн жагсаалт, бүтээгдэхүүний төрөл, тоо хэмжээг тогтоох тухай Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулан бүх яамдаас санал авч нэгтгэн, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, шийдвэрлүүлэхээр 2019.10.18-ны өдрийн 01/2939 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Энэхүү асуудлыг Засгийн газрын 2019 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж, Газрын тосны бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх тухай 409 дугаар тогтоол гарсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 8 | 5. Аймаг, нийслэл, сумдын хэрэглээнд үндэслэн шатахуун түгээх станц, агуулахын оновчтой сүлжээг бий болгох | 2018 - 2020 | УУХҮЯ /ХҮГТБХЗГ/ | | Холбогдох байгууллагууд тай хамтарсан ажлын хэсэг байгуулж, судалгааны ажлыг эхлүүлэх | АМГТГ-ын даргын 2018.05.03-ны өдрийн А/61 дугаар тушаалын дагуу хамтарсан ажлын хэсэг ажиллаж, хүн амын нягтаршил ихтэй хот, суурин газар болон төв замын дагуу үйл ажиллагаа явуулж байгаа газрын тосны бүтээгдэхүүний агуулах, шатахууун түгээх станц, хийн байгууламжуудын улсын үзлэгийг зохион байгуулсан. Үзлэгээр Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Увс, Ховд, Өмнөговь, Дундговь, Дорноговь, Говьсүмбэр, Говь-Алтай, Сүхбаатар, Дорнод зэрэг нийт 12 аймгийн 120 суманд байрлах агуулах, түгээх станцуудын техник технологийн байдалд түвшин тогтоох үзлэг зохион байгуулсан ба үзлэгт хамрагдсан компаниудын шатахуун хадгалах савны бүртгэлийг шинэчилж байна. Аймаг, нийслэл, сумдын хэрэглээнд үндэслэн шатахуун түгээх станц, агуулахын оновчтой сүлжээг бий болгох судалгааны ажлын хүрээнд: 1.ArcGIS форматын Web хийлгэж байгаатай холбогдуулан газрын тосны бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх станц, шингэрүүлсэн шатдаг хийн хий цэнэглэх станц, автомашин хийгээр цэнэглэх станцын холбогдох мэдээллүүдийн талаарх судалгааны ажлыг эхлүүлсэн. 2.Австрали-Монголын Эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөрийн (AMEP) төслийн хүрээнд ArcGIS Explorer дээр суурилсан Үндэсний Геологи, Эрдэс Баялгийн Мэдээллийн Сан Төсөл буюу МонГеоКолл системд хийн болон шатахуун түгээх станцуудын байршлын цэгүүдийн мэдээллийг нэгтгэсэн. 3.ArcGIS форматын программын сүлжээнд Улаанбаатар хот болон 21 аймгийн агуулах, түгээх станцын мэдээллийг нэгтгэн оруулсан. Улсын хэмжээнд улсын үзлэгийн шинэчилсэн дүнгээр 110 агуулах, 1289 шатахуун түгээх станц, 12 шингэрүүлсэн шатдаг хий хадгалах агуулах, 86 гаруй шингэрүүлсэн шатдаг хий түгээх станцуудаар дамжуулан газрын тосны бүтээгдэхүүний хадгалалт, түгээлт, борлуулалтын үйл ажиллагаа явуулж байна.<br>Аймаг, нийслэл, сумдын хэрэглээнд үндэслэн шатахуун түгээх станц, агуулахын оновчтой сүлжээг бий болгох судалгааны ажлын хүрээнд: Монгол Улсын хэмжээнд газрын тосны бүтээгдэхүүний жижиглэнгийн худалдаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагын шатахуун түгээх станцын оновчтой сүлжээг бий болгох тухай ажлын хүрээнд Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймаг, 330 сумын хүн амын тоог 2017 оны байдлаар авч Төрөөс газрын тосны бүтээгдэхүүний чиглэлээр хэрэгжүүлж буй бодлогыг хэрэгжүүлэх, олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй, ил тод байх ажлын хүрээнд Эрдэс баялгийн салбарт Австрали-Монголын хамтын ажиллагааны хөтөлбөрөөр (AMEP) хийгдэж буй MonGeoCall (arcgis) web программд Улаанбаатар хот, аймаг, сумдын газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээнд тулгуурлан бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагын агуулах, шатахуун түгээх станц, хийн байгууламжийн мэдээллийг цахим хэлбэрт бүртгэлжүүлэн, байршлын цэгүүдийн мэдээллийг нэгтгэсэн ба ArcGIS форматын программын сүлжээнд Улаанбаатар хот болон 21 аймгийн агуулах, түгээх станцын мэдээллийг нэгтгэн оруулсан. Улсын хэмжээнд улсын үзлэгийн шинэчилсэн дүнгээр 110 агуулах, 1289 шатахуун түгээх станц, 12 шингэрүүлсэн шатдаг хий хадгалах агуулах, 86 гаруй шингэрүүлсэн шатдаг хий түгээх станцуудаар дамжуулан газрын тосны бүтээгдэхүүний хадгалалт, түгээлт, борлуулалтын үйл ажиллагаа явуулж байна.<br>УУХҮЯ-ны захиалгаар “Ухаалаг шийдэл” ХХК-ийн боловсруулсан “Газрын тосны бүтээгдэхүүний цахим сан байгуулах судалгаа”-ны ажлыг 2019 оны 07 дугаар сараас 12 дугаар сарын хооронд хийж гүйцэтгүүлэн тайланг хүлээн аваад байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 9 | 6. Шатахуун импортлох, үйлдвэрлэх, хадгалах, бөөн болон жижиглэнгээр борлуулах үеийн чанарын хяналтын тогтолцоог сайжруулах | 2016 - 2020 | УУХҮЯ /ХҮГТБХЗГ/ | | Ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн чанарын хяналтын тогтолцоог сайжруулах төлөвлөгөө боловсруулах | 1. Монгол Улсын Шадар сайдын 2019.02.25-ны өдрийн 14 дүгээр тушаалаар байгуулагдсан газрын тосны бүтээгдэхүүнд чанарын хяналт, шалгалт хийж, дүгнэлт гаргах үүрэг бүхий дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллан, хүрээнд хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хяналтын тогтолцоо бүрдүүлэх асуудлаар санал, дүгнэлт боловсруулж, мэдээ мэдээллээр хангаж ажилласан. БНСУ-ын К-Петро байгууллагатай хамтран 2019.07.03-05-ны өдрүүдэд “Шатахууны чанарын хяналтын менежментийн систем, технологи, БНСУ-ын туршлага” сэдэвт семинарыг зохион байгуулсан ба тус семинарт төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын 120 гаруй төлөөлөгчид оролцсон. Шатахууны чанарын хяналтын тогтолцоо бүрдүүлэх ажлын хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны төсвийн хөрөнгө оруулалтаар “Газрын тосны бүтээгдэхүүний цахим сан байгуулах” зөвлөх үйлчилгээ үзүүлэх” эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг “Ухаалаг шийдэл” ХХК-иар тендерийн дагуу гүйцэтгүүлэн, судалгааны ажлын тайлан, программ хангамжийг хүлээж авсан. Шатахууны хангамж, чанарын хяналтын тогтолцоо бүрдүүлэх, ажлын уялдаа холбоог сайжруулах, мэдээлэл, хяналтын нэгдсэн систем бий болгох, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр хамтран ажиллах тухай 2019.02.19-ний өдрийн 03/441 тоот албан бичгийг ШӨХТГ-т хүргүүлэн хамтран ажиллаж байна.<br>2. Шатахууны онцгой албан татварын хэмжээг чанар, стандарттай уялдуулан тогтоох, автобензин, дизель түлш үйлдвэрлэх зориулалтаар импортолж буй үндсэн /керосин, нафта зэрэг/ болон нэмэлт бүтээгдэхүүнд онцгой албан татвар ногдуулах хууль, эрх зүйн орчин бүрдүүлэх тухай Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2019.03.13-ны өдрийн 01/637 тоот албан бичгээр Сангийн яаманд дахин хүргүүлсэн. Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өмнө нь 2017 оны 12 дугаар сар, 2018 оны 11 дүгээр саруудад Сангийн яаманд тус тус хүргүүлж байсан болно.<br>3. ОХУ-ын Роснефть компаниас 2018 оноос хойш манай улсад нийлүүлсэн шатахууны нийт тоо хэмжээг импортолсон компани тус бүрээр стандарт, нэр төрлөөр нь гарган ирүүлэх тухай 2019.10.31-ний өдрийн 07/3062 тоот албан бичгийг “Роснефть Монголия” ХХК-д хүргүүлсэн. Роснефть компанитай 2018 онд байгуулсан шатахуун худалдах, худалдан авах гэрээний үнэ тооцох аргачлалын премиум буюу нэмэгдлийг бууруулах, Евро-5 /К-5/ ангиллын шатахууны хэмжээг 2020 оны 6 дугаар сараас эхлэн нийт бүтээгдэхүүний 50 хувьд хүргэх тухай 2019.10.29-ний өдрийн 03/3020 тоот албан бичгийг "РОСНЕФТЬ" ХК-ийн Худалдаа, тээвэр хариуцсан Дэд ерөнхийлөгч Отабек Каримовт хүргүүлэв. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 10 | | 7. Гашуун сухайт, Ханх, Хавирга зэрэг боомтуудаар бүтээгдэхүүн тогтмол импортлох ажлыг эхлүүлэх, улмаар тээвэр ложистикийн зардлыг бууруулах, өртгийг багасгах судалгаа хийх | 2016 - 2020 | УУХҮЯ /ХҮГТБХЗГ/ | 50 | Судалгааны ажлын үр дүнг нэгтгэж, ажлын хэсгийн зөвлөмжийг үндэслэн холбогдох шийдвэрийг гаргах | БНХАУ-аас Өмнөговь аймгийн Гашуун сухайт, Шивээ хүрэнгийн боомтоор автоцистернээр шатахуун импортлохтой холбоотойгоор тухайн боомтуудын хил, гаалийн нөхцөл байдал, тусгай терминал байгуулах шаардлагатай эсэх, тээвэрлэлтийн асуудлаар ЗТАЖЯ, ГЕГ, Автотрээврийн үндэсний төв зэрэг газруудад албан бичиг явуулан хариуг аваад байна. Монгол Улс, БНХАУ-ын Засгийн газар хоорондын автотээврийн хэлэлцээрийг хэрэгжүүлэх тухай хоёр улсын Зам, тээврийн яам хоорондын протоколд улс хоорондын аюултай ачаа тээвэрлэлтэд гүйцэтгэхэд "F" төрлийн онцгой зөвшөөрөл авахаар заасан ба тус зөвшөөрлийг Автотээврийн үндэсний төвөөс олгож байгаа тухай хариуг ЗТХЯ-наас ирүүлсэн. ГЕГ-аас Гашуунсухайт боомтоор шатахуун импортлоход гаалийн байгууллагын хүний нөөц, гаалийн хяналтын бүсийн нөхцөл шаардлага, эрх зүйн зохицуулалтын хувьд хүндрэлгүй гарахгүй, бүх төрлийн шатахууны гаалийн бүрдүүлэлт хийхэд шаардлагатай гаалийн лаборатори одоогоор байхгүй байгаа боловч 2019 оны төсөвт тус боомтод гаалийн лаборатори байгуулахаар тусгагдсан тухай хариу ирүүлсэн. Иймд БНХАУ-ын Чайна ойл компанитай 2019 оны 04 дүгээр сар, 07 дугаар саруудад уулзалт, хэлэлцээр хийж холбогдох асуудлаар санал солилцсон ба шатахуун импортлох нөхцөлийг бүрдүүлэх асуудлаар 2 талын хил, гааль, тээвэр хариуцсан байгууллагуудтай хэлэлцэх, холбогдох бичиг баримтыг бүрдүүлэх, зөвшөөрөл авах ажлуудыг хийж гүйцэтгэхээр тохиролцсон. М-Ойл компани болон Чайна ойл компаниудын хооронд байгуулсан шатахуун худалдах, худалдан авах гэрээний хүрээнд хятадын талын шатахуун тээврийн 4 автоцистернд хоёр талын тээврийн байгууллагаас холбогдох зөвшөөрлийг аваад байсан боловч Хятадын талын боомтын аюултай ачаанд хяналт хийх талбайтай холбоотойгоор тус асуудал хойшлоод байна. | 70 |
| 11 | 2.48.Үйлдвэржилтийн 21:100 хөтөлбөрийг хэрэгжүүлж, импортыг орлох экспортын чиглэлийн тэргүүлэх болон жижиг, дунд үйлдвэрлэл, хоршоо, худалдаа, үйлчилгээний салбарын татвар, эрх зүй, бизнесийн таатай орчинг бүрдүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн | 6. "Үйлдвэржилт 21:100" хөтөлбөрийг боловсруулан батлуулах | 2017 - 2020 | ХХААХҮЯ УУХҮЯ /ХҮГТБХЗГ/ | | Хөтөлбөрий г хэрэгжүүлэх | ХХААХҮЯ-ны ТНБД-ын 2016 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн А/157 дугаар тушаалаар байгуулагдсан "Үйлдвэржилт 21:100 хөтөлбөр"-ийг боловсруулж батлуулах үүрэг бүхий Ажлын хэсэгт яамны төлөөлөл орж ажиллав. Ажлын хэсгээс Монгол Улсад хүнд, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төслүүдийн танилцуулгыг боловсруулан Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж Засгийн газрын хуралдааны 2016 оны 60 дугаар тэмдэглэл гарсан. Уг тэмдэглэлд Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд заасны дагуу Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах тухай санал гарсны дагуу ажлын хэсэг "Үйлдвэржилт 21:100 хөтөлбөрийг боловсруулж, яамдаас санал авч Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлэн болгосон байна. Энэхүү ажлын хүрээнд Үндэсний аж үйлдвэрийн зөвлөл болон салбарын эрдэмтэн, доктор, ААН-үүдийн удирдлагуудтай 21:100 хөтөлбөрийн төслийг хэлэлцүүлэх ажлыг УУХҮЯ-нд 2017 оны 03 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулав. Хүнд үйлдвэрийн зөвлөлөөс 2017 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 17/47 тоот албан бичгээр ирүүлсэн саналыг Ажлын хэсэгт хүргүүлэв. ХХААХҮЯ-ны 2017 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 01/1470 дугаар албан бичгийн хавсралтаар ирүүлсэн "Үйлдвэржилт 21:100" хөтөлбөрийн төсөлд санал боловсруулж, 2017 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 01/1159 тоотоор хариу хүргүүлсэн. Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 31 –ний 36 дугаар тогтоолоор 21:100 хөтөлбөр батлагдсан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 12 | дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээг нэмэгдүүлнэ. | 7. "Үйлдвэржилт 21:100" хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд 21 аймагт 100 нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэр байгуулахад санхүү, эрх зүйн дэмжлэг үзүүлж ажиллах | 2017 - 2020 | ХХААХҮЯ УУХҮЯ /ХҮГТБХЗГ/ | | Үйлдвэрүүдийн үйл ажиллагаа эхлүүлж, туршилт тохируулга хийгдэх, дэд бүтцийн бүтээн байгуулалтын 45-60 хувь нь хийгдэх | Тус хөтөлбөрт тусгагдсан "Ачааны вагон угсрах үйлдвэр" байгуулах төслийг хэрэгжүүлэхээр "МТЗ" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2015 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн А/33 тоот тушаал, 2016 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/34 тоот тушаалаар төслийн УТЭЗҮ боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажилласан. Тус ажлын хүрээнд "Дорноговь аймгийн Сайншанд сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт 43 га газарт "Ачааны вагон угсрах үйлдвэр"-ийг барихаар төлөвлөн, Украйн улсын "Техвагонмаш" компаниас ирүүлсэн вагоны засвар, угсралтын төв байгуулах төслийн дэлгэрэнгүй танилцуулгыг урьдчилсан ТЭЗҮ-д тусгаж төслийг үргэлжлүүлэн хөгжүүлэх ажлууд хийгдсэн ба ЗТХ-ийн сайдын техникийн зөвлөлийн хуралдаанаар уг төсөл дэмжигдэн 2017 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 83 тоот тушаалын дагуу ЗТХЯ-ны удирдлаган дор "МТЗ" ТӨХК нь "УБТЗ" ХНН-тэй хамтран дотооддоо ачааны вагон угсрах ажлыг эхлүүлсэн. | 70 |
| 13 | 2.59.Монгол орны геологийн зураглал, ерөнхий эрэл, агаарын геофизик, геохими, гидрогеологи, геоэкологийн судалгааны ажлын хэмжээг нэмэгдүүлэх замаар уул уурхайн салбарын тогтвортой хөгжлийг дэмжинэ. | 1. Геологийн 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн ажлын хэмжээг нэмэгдүүлж, нутаг дэвсгэрийн 45 хувийг хамруулах | 2016 - 2020 | УУХҮЯ /ГУУБХЗГ/ | Батлагдсан – 10,404.8 Гүйцэтгэл – 1,628.3 Санхүүжилт – 1,628.3 | 7600 Улсын төсөв Нутаг дэвсгэрийн 45 хувийг хамруулж, геологийн тогтоц, ашигт малтмалын хэтийн төлвийн үнэлгээг өгөх | Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн Тэрэм уул-50, Тэзгийн гол-50, Сант-50, Баян-Индэр-50 төслүүдийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн хуралдааны дүгнэлтийг үндэслэн УУХҮС-ын 2020 оны А/35, А/39, А/149, А/150 дугаар тушаалаар хүлээн авсан. Дээрх 4 төслийг хэрэгжүүлснээр 12,370.21 кв.км талбай буюу 0.8%-ийг бүрхсэн ба нийт нутаг дэвсгэрийн 41%-ийг бүрэн бүрхээд байна. Эдгээр талбайд 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлаар бүрхсэнээр тухайн талбайд тархсан төрөл бүрийн хурдас чулуулгийн тархалт, хил зааг, нас, найрлага зэргийг тодорхойлон зурагласан бөгөөд ашигт малтмалын хэтийн төлөвийг тодруулж, хэтийн төлөвтэй талбайг ялгасан. Дээрх 4 төслийн талбайн хэмжээнд ялгасан ашигт малтмалын хэтийн төлөвтэй бүхий эрдсийн хуримтлалтай талбайнууд нь хуулиар хориглосон, хязгаарласан газруудтай давхцалгүй бөгөөд ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох боломжтой талбайнууд юм. 2020 онд энэ төрлийн 42 төслийг нутаг дэвсгэрийн 5%-д хэрэгжүүлэн ажиллахаар төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын 2019 оны А/254 дүгээр тушаалаар батлан суурин болон хээрийн судалгааны ажлыг эхлүүлсэн. 2020 онд үргэлжлэн хэрэгжих 27 төслийн 2020 оны ажлын хэмжээ, арга, аргачлал, төсвийг хэлэлцсэн ЭБМЗ-ийн дүгнэлтийг үндэслэн УУХҮС-ын 2020 оны А/112 - А/122, А/128, А/131 - А/142, А/144 - А/146 дугаар тушаалаар баталсан. Мөн 2020 онд шинээр Овоот толгой-50, Үүрэг нуур-50, Улаангом-50, Уушгийн улаан-50, Торлог уул-50, Цээл-50, Хар хайрхан-50, Номингийн говь-50, Их бэрх уул-50, Цэцэрлэг-50, Их элээт уул-50, Их хараат уул-50, Үнэгт уул-50, Цагаан овоо-50, Индэртийн нуруу-50, нийт 15 төслийг шинээр хэрэгжүүлэхээр геологийн даалгаврыг боловсруулан УУХҮ-ийн дэд сайдаар 2020оны 2-р сарын 14-ний өдөр батлуулсан. Төслийн гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг цахимаар зарлан 6-р сарын 16-ны өдрийн байдлаар тендерт шалгарсан 6 гүйцэтгэгч нартай зөвлөх үйлчилгээний гэрээг тендер хүчинтэй байх хугацаанд буюу 6-р сарын 12-ны өдөр байгуулсан. Төлөвлөгөөт онд хэрэгжүүлэх энэ төрлийн судалгааны ажил нь дээр өгүүлсний дагуу нутаг дэвсгэрийн 5%-д хэрэгжвэл нутаг дэвсгэрийн 45%-ийг хамруулах боломжтой болно. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 14 | 2. Улсын геологийн 1:200000-ны масштабын зургийг нэгтгэх | 2017 - 2020 | УУХҮЯ /ГУУБХЗГ/ | Батлагдсан – 1,770.9 Гүйцэтгэл – 692.5 Санхүүжилт - 692.5 | 1,400.0 Улсын төсөв K, L номенклатурын хэмжээнд нэгтгэлийн ажлыг дуусгаж, мэдээллийн санг бүрдүүлэх | Улсын геологийн иж бүрдэл зургийг K, L, M (N) хавтгайн хэмжээнд нэгтгэх төслийн 2020 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын 2019 оны А/254 дүгээр тушаалаар батлуулж K хавтгайн суурин боловсруулалт, L хавтгайн суурин болон хээрийн судалгааны ажлыг эхлүүлсэн. Мөн дээрх 2 төслийн 2020 оны хээрийн болон суурин боловсруулалтын судалгааны ажлын хэмжээ, арга аргачлал, төсвийг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцэж УУХҮС-ын А/127, А/130 дугаар тушаалаар баталсан. Монгол орны M (N) хавтгайн хэмжээнд иж бүрдэл зургийг нэгтгэх ажлыг 2020 онд эхлүүлэхээр УУХҮС-ын А/254 дүгээр тушаалаар төлөвлөгөө, төсвийг баталсан. Судалгааны ажлын геологийн даалгаврыг УУХҮ-ийн дэд сайдын 2020 оны2-р сарын 14-ний өдрийн шийдвэрээр баталсан. Төслийн ажлыг гүйцэтгэх зөвлөхийг сонгон шалгаруулах тендерийг цахимаар зохион байгуулж гүйцэтгэгчээр шалгарсан хуулийн этгээдтэй гэрээг 6-р сарын 12-нд байгуулсан. Улсын геологийн иж бүрдэл зургийг K, L, M (N) хавтгайн хэмжээнд нэгтгэх ажилд 2020 онд 1.8 тэрбум төгрөгийг зарцуулахаар батлуулж, санхүүжилтийг эхний хагас жилийн байдлаар 692,498,615 төгрөгийг олгоод байна. | 70 |
| 15 | 3. Монгол Улсын баруун өмнөд хэсгийг хамарсан талбайд агаарын геофизикийн цогцолбор судалгааны ажлыг хэрэгжүүлэх | 2016 - 2020 | УУХҮЯ /ГУУБХЗГ/ | Батлагдсан – 900.0 Гүйцэтгэл - 0.0 Санхүүжилт - 0.0 | 1500.0 Улсын төсөв Ховд-I төслийн үр дүнг хүлээн авч нутаг дэвсгэрийн 6 хувийг хамруулах | Монгол орны баруун хэсэг буюу 104,044.0 кв.км талбай /6.6%/-г хамарсан агаарын геофизикийн 1:200000-ны масштабын 5 сувгийн судалгааны ажлыг 2020 онд хэрэгжүүлэхээр геологийн даалгаврыг боловсруулан УУХҮ-ийн дэд сайды 2020 оны 2-р сарын 14-ний өдрийн шийдвэрээр, УУХҮС-ын 2019 оны А/254 дугаар тушаалаар төсөв, төлөвлөгөөг тус тус батлуулсан. Энэхүү Ховд-2020 төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2020.03.20-ны өдөр цахимаар зохион байгуулсан хэдий ч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, тендерийн баримт бичигт заасан шалгуурыг хангасан хуулийн этгээд шалгараагүй тул дахин тендерийг 5-р сарын 11-ний өдөр зарлаад байна. Судалгааны ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн ажиллагаа хийгдэж байна. | 40 |
| 16 | 4. Монгол Улсын нутаг дэвсгэрийг хамарсан геохимийн судалгаа хийх | 2017 - 2020 | УУХҮЯ /ГУУБХЗГ/ | Батлагдсан – 1,623.5 Гүйцэтгэл – 136.4 Санхүүжилт – 136.4 | 400.0 Улсын төсөв Геохимийн суурь судалгааны ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд | Монгол орны нутаг дэвсгэрийн 1,1 сая кв.км талбай /73.5%/-г хамарсан 1:1000000-ны масштабын геохимийн зураглал хийх, дагалдах мэдээллийн сан бүрдүүлэх судалгааны ажлыг 2020 онд үргэлжлэн хэрэгжүүлэхээр УУХҮС-ын 2019 оны А/254 дүгээр тушаалаар төсөв, төлөвлөгөөг батлуулж суурин боловсруулалт, хээрийн судалгааны ажлын бэлтгэл ажлыг эхлүүлсэн. Төлөвлөгөөт онд Монгол орны төв хэсэг буюу L-47,48, 49, M-47, 48, 49 хавтгайд хээрийн судалгааны дээжлэлтийн ажлыг хийж байна. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 17 | 5. Дэд бүтцийн бүтээн байгуулалт хийгдэх газар болон томоохон хот суурин газрын геоэкологийн болон гидрогеологийн сэдэвчилсэн судалгааны ажил хийх | 2017 - 2020 | УУХҮЯ /ГУУБХЗГ/ | Батлагдсан – 634.5 Гүйцэтгэл – 158.1 Санхүүжилт - 158.1 | 200.0 Улсын төсөв Дэд бүтцийн бүтээн байгуулалт хийгдэж байгаа нутаг дэвсгэрт геоэкологи, гидрогеологийн сэдэвчилсэн судалгааны ажлыг | 1. Улаанбаатар хотын геоэкологи, гидрогеологи-2017 төслийн суурин болон хээрийн судалгааны ажлыг 2017-2019 онд хэрэгжүүлэн дуусгасан бөгөөд төслийн үр дүнгийн тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. 2.<br>Эрдэнэт хотын геоэкологи, гидрогеологийн судалгааны ажлыг 2020 онд үргэлэн хэрэгжүүлэхээр төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын А/254 дүгээр тушаалаар батлуулсан. Төслийн суурин болон хээрийн судалгааны ажлын хэмжээ, арга аргачлалыг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн УУХҮС-ын 2020 оны А/126 дугаар тушаалаар батлаж судалгааны ажлыг эхлүүлээд байна.<br>3. Дархан хотын геоэкологи, гидрогеологийн судалгааны ажлыг 2020 онд хэрэгжүүлэхээр төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын 2019 оны А/254 дүгээр тушаалаар, ажлын даалгаврыг УУХҮ-ийн дэд сайдын 2020 оны 2-р сарын 14-ний өдрийн шийдвэрээр тус тус баталсан. Судалгааны ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг цахимаар зарлаж гүйцэтгэгч хуулийн этгээдийг шалгаруулан зөвлөх үйлчилгээний гэрээг 2020 оны 6-р сарын 12-ны өдөр байгуулсан. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 18 | 6. Эрдэс баялгийн хэтийн төлөв бүхий хүдрийн бүс, сав газар, улсын хил орчмын нутаг дэвсгэр, дэд бүтцийн бүтээн байгуулалтын төлөвлөлттэй уялдуулан сэдэвчилсэн судалгааны төсөл хэрэгжүүлэх | 2017 - 2020 | УУХҮЯ /ГУУБХЗГ/ | Батлагдсан-6,546.2 Гүйцэтгэл-1,234.3 Санхүүжилт – 1,234.3 | 5300.0 Улсын төсөв Ашигт малтмалын хэтийн төлвийн судалгааны ажлыг хэрэгжүүлж эхлэх | 1. Бүс нутгийн хөгжлийг хангах, эрдэс түүхий эдийн нөөц, баялгийг өсгөх зорилгоор нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд тархсан голлох ашигт малтмалын судалгаа (АМС-2017)-ны ажлын 2019 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын 2019 оны А/254 дүгээр батлуулсан. Судалгааны ажлын 2020 оны төсөл, төсвийн тодотголыг УУХҮС-ын 2020 оны А/123 дугаар тушаалаар батлуулж, суурин болон хээрийн судалгааны ажлыг эхэлсэн. Төлөвлөгөөт онд хээрийн судалгааны ажлаар хэтийн төлөв бүхий хэд хэдэн талбайд нарийвчилсан эрлийн ажил, уул-өрөмдлөгийн ажил, эрэл шалгалтын ажил хийхээр төлөвлөж хээрийн үйлдвэрлэлийн ажлыг 2020.05.15-ны өдрөөс эхэлсэн. 2.Стратегийн ашигт малтмал (ГАСАМ)-ын судалгааны ажлыг төлөвлөгөөт онд үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр УУХҮС-ын 2019 оны А/254 дүгээр тушаалаар төлөвлөгөө, төсвийг батлуулсан. Судалгааны ажлын хэмжээ, арга аргачлал, төсвийг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцэн гаргасан дүгнэлтийг үндэслэн УУХҮС-ын 2020 оны А/143 дугаар тушаалаар батлуулан суурин болон хээрийн судалгааны ажлын бэлтгэл ажлыг эхлүүлсэн. Стратегийн ашигт малтмалын төрлүүдийг тектоник, металлогени болон бусад геологийн хүчин зүйлс, дэд бүтэц зэрэг нийгэм-эдийн засгийн хүчин зүйлүүдтэй хамтатган судалж, өнөөдрийн нөхцөлд стратегийн ашигт малтмал гэж авч үзэх төрлүүдийг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн тодорхойлох, үнэлэлт, дүгнэлт өгөх, энэхүү судалгааны үр дүнд дэлхийн түүхий эдийн зах зээл дээр эрэлт ихтэй өндөр технологийн болон энергийн түүхий эдийг нарийвчлан судалж, Монгол Улсын экспортын чиг хандлагыг тодорхойлох суурь судалгааны энэ ажилд 0.6 тэрбум төгрөг зарцуулахаар баталсан. 3. Голлох ашигт малтмалын судалгаа (АМС-2017) төслийн ажлын үр дүнд тогтоогдсон ашигт малтмалын хэтийн төлөвтэй 3 талбай буюу Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын нутагт орших 245.01 кв.км талбайд үнэт, холимог металлын чиглэлээр эрэл-үнэлгээний ажил (ЭҮ-1-2020)-ыг шинээр хэрэгжүүлэхээр төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын 2019 оны А/254 дүгээр тушаалаар, геологийн даалгаврыг УУХҮ-ийн дэд сайдын 2020.2.14-ний өдрийн шийдвэрээр батлуулсан. Төслийн ажлыг гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг цахимаар зохион байгуулж шалгарсан этгээдтэй 6-р сарын 12-ны өдөр гэрээ байгуулсан. 4. Голлох ашигт малтмалын судалгаа (АМС-2017) төслийн ажлын үр дүнд тогтоогдсон ашигт малтмалын хэтийн төлөвтэй 5 талбай буюу Өмнөговь аймгийн Цогтцэций, Мандал-Овоо, Ханбогд, Манлай, Баян-Овоо, Дорноговь аймгийн Мандах сумын нутагт орших 200.54 кв.км талбайд үнэт, өнгөт, хар, ховор, холимог металлын чиглэлээр эрэл-үнэлгээний ажил (ЭҮ-2-2020)-ыг шинээр хэрэгжүүлэхээр төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын 2019 оны А/254 дүгээр тушаалаар, геологийн даалгаврыг УУХҮ-ийн дэд сайдын 2020.2.14-ний өдрийн шийдвэрээр батлуулсан. Төслийн ажлыг гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг цахимаар зохион байгуулан ажиллаж байна. | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 8. Цацраг идэвхт ашигт малтмал болон газрын ховор элементийн геологи хайгуулын ажлыг төлөвлөх | 2016 - 2020 | УУХҮЯ /ГУУБХЗГ/ | | Цацраг идэвхт ашигт малтмал, газрын ховор элементийн батлагдсан нөөцөөр дэлхийд эхний 10 улсад багтах | Цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын ажилд хэрэглэх аргачилсан зөвлөмжүүдийг боловсруулах ажлыг зохион байгуулж, зөвлөмжүүдийг холбогдох материалын хамт ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн ХХ-09-01-01, ХХ-05-2-02 дугаар зөвлөмж гарсан.<br>-Төрийн өмчит “Мон-Атом” ХХК-аас Дорноговь аймгийн Сайншанд суманд зохион байгуулагдсан уулзалт, зөвлөлгөөнд оролцож хамтарсан төслийн үйлдвэрлэлийн туршилт эхлэхтэй холбогдуулж аюулгүй байдал, хяналт удирдлага, тулгамдаж буй асуудлуудаар мэдээлэл авч, санал солилцсон.<br>-Цөмийн энергийн тухай хуулийн 9.1.2, 28.9, 28.10-т заасныг үндэслэн Зөөвч-Овоо ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Бадрах энержи” ХХК-аас байгаль орчин хамгаалах, цөмийн болон цацрагийн ослоос сэргийлэх үүргээ биелүүлэх баталгаа болгон мөнгөн хөрөнгийг төрийн сангийн дансанд байршуулах тухай Засгийн газрын 2018 оны 371 дүгээр тогтоол дагуу Төрийн санд мөнгөн хөрөнгө байршуулах гэрээний төслийг боловсруулж, СЯ, БОАЖЯ, МХЕГ, ЦЭК, АМГТГ-аас холбогдох саналыг авч тусгасан. Гэрээг 2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр талууд байгуулсан.<br>-Улсын хэмжээнд 2018 оны 12 дугаар сарын байдлаар Дорноговь, Өмнөговь, Ховд аймгийн нутагт газрын ховор элементийн 4 үндсэн орд (Лугийн гол, Хотгор, Мушгиа худаг, Халзан бүрэгтэй)-ын хэмжээнд металлуудын исэл хэлбэрээр нийт 2,985,326.3 орчим тонн, ашигт малтмалын нөөцийн нэгдсэн санд бүртгэгдсэн батлагдсан нөөц 151,139.05 тонн байна. Цацраг идэвхт ашигт малтмалын чиглэлээр хайгуулын 14, ашиглалтын 9 тусгай зөвшөөрлийг 12 аж ахуйн нэгж эзэмшин 8 аймгийн 23 сумын нутагт нийт 524.6 мянган гектар талбайд үйл ажиллагаа явуулж байна.<br>Газрын ховор элементийн нөөц бүхий 4,512,265.63 гектар талбай буюу 167 талбайг бусад ашигт малтмалын талбайгаас ялган Кадастрын бүртгэлийн системд бүртгэсэн байна. Цацраг идэвхт ашигт малтмалын 11 ордын мэдээлийн санг бүрдүүлсэГазрын ховор элемент хөтөлбөрийн төслийг Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн дагуу боловсруулж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулахаар 2018 оны 01/3230 тоот албан бичгээр хүргүүлсэн. ҮАБЗ-өөс өгсөн чиглэлийн дагуу газрын ховор элементийн өнөөгийн байдал цаашид авах арга хэмжээний талаар танилцуулга бэлтгэн Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 09-ний хуралдаанд танилцуулж Засгийн газрын хуралдааны тэмдэглэл гаргуулсан. Газрын ховор элемент хөтөлбөрийн төслийг Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмын дагуу боловсруулан холбогдох судалгааг хийж 2020 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 01/1512 дугаар албан бичгээр яамдаас санал авахаар хүргүүлээд байна.<br>-Газрын ховор элементийн геологийн судалгаа, хайгуулын ажлыг нэмэгдүүлэх, цаашдын чиг хандлагыг тодорхойлох, судалгааны түвшинг дээшлүүлсний үндсэн дээр шинээр орд газруудыг тогтоож, улсын эрдэс баялгийн санг арвижуулах, бэлтгэгдсэн орд газруудыг олборлох, хүдрийг боловсруулж нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар эдийн засгийн эргэлтэд шинээр оруулах хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, эдийн засгийн үр ашгийг тооцох үүрэг бүхий төслийн нэгжийг ЗГ-ын 2019 оны 176 дугаар тогтолоор байгуулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 20 | 9. Цацраг идэвхт ашигт малтмал болон газрын ховор элементийн нөөц бүхий ордод стратегийн хөрөнгө оруулагчдыг сонгох, хамтарсан компани байгуулах | 2016 - 2020 | УУХҮЯ /ГУУБХЗГ/ | | Цацраг идэвхт ашигт малтмал, газрын ховор элементийн эрэл, хайгуулын ажлын үр дүнгээр нөөцийн тодорхой түвшинд хүрэх | Стратегийн хөрөнгө оруулагчаар Франц Улстай "Арева майнс" ХХК, Чех Улстай "Гурван сайхан" ХХК-ийг тус тус сонгож, эзэмшиж байгаа ордод хамтран ажиллаж байна. Чех улсын хөрөнгө оруулалттай, хамтарсан "Гурвансайхан" ХХК, Франц улсын хөрөнгө оруулалттай "Бадрах энержи" ХХК-ний компанийн нийт хувьцааны Засгийн газарт ноогдох 15-34 хувийг төрийн өмчит "Мон-Атом" ХХК-д шилжүүлэх ажлыг хэрэгжүүлж байна.<br>-Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутагт орших Зөөвч овоогийн ураны ордод үйл ажиллагаа явуулж буй "Бадрах Энержи" ХХК-ийн туршилтын уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах комиссыг Уул уурхай, хүнд үйлдвэр, Барилга, хот байгуулалтын сайд нарын хамтарсан 2019 оны А/18/16 дугаар тушаалаар батлуулж, 2019.01.26-ны өдөр үйлдвэрийн барилга байгууламж, дэд бүтцийн бүтээн байгуулалттай газар дээр нь ажиллаж, холбогдох дүгнэлтийг боловсруулсан. Улмаар Засгийн газрын 2018 оны 371 дүгээр тогтоолын дагуу УУХҮЯ болон "Бадрах Энержи" ХХК хооронд байгуулах Зөөвч Овоо ордын технологийн туршилттай холбогдуулан Төрийн санд мөнгөн хөрөнгө байршуулах тухай гэрээний төслийг боловсруулж уг тусгай зөвшөөрөл эзэмшигчид хүргүүлсэн болно.<br>-Дулаан-Уул (MV-018914, MV- 018916), Зөөвч-Овоо (MV- 018915) ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг Франц-Монголын хамтарсан Арева майнс компанийн нэр дээр шилжүүлэв. Ингэснээр хувьцаа эзэмшигчдийн гэрээний дагуу албан ёсоор үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Гурвансайхан компанийн эзэмшиж буй орд газруудын төрийн эзэмшилийн хувь хэмжээг шилжүүлэх ажлыг зохион байгуулахаар орд эзэмшигч төрийн өмчит компаниудтай хэлцэл хийх ажлыг зохион байгуулсан. Орд эзэмшигчид хооронд хөрөнгө оруулалтын маргаан үүсч Канадын Денисон Майнз компани Чех улсын Ураниум Индастри группыг олон улсын арбитрын шүүхэд өгсөнөөс шалтгаалан хувьцаа шилжүүлэх үйл ажиллагаа түр хойшлогдоод байна. Бусад ордуудын хувьд хамтарсан компани байгуулах, стратегийн хөрөнгө оруулагчийг сонгох зэрэг ажлууд бэлтгэл шатандаа явж байна.<br>-Цацраг идэвхт ашигт малтмал болон газрын ховор элементийн нөөц бүхий ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч 21 аж ахуйн нэгжүүдийн төлөөлөлтэй 2019 оны 02 дугаар сарын 14-ны өдөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, холбогдох газрын дарга нар уулзалт хийсэн. Тус уулзалтаар нийт тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд тулгамдаж буй асуудлууд түүнийг хэрхэн шийдвэрлэх талаар санал солилцсон. Уг саналыг Газрын ховор элемент хөтөлбөрт тусгаж 2020 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 01/1512 дугаар албан бичгээр яамдаас санал авахаар хүргүүлээд байна. Мөн ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалд хэрэглэх аргачилсан зөвлөмж ШУТИС-ийн Геологи уул уурхайн сургуулийн харъяа Эрдэс баялгын судалгаа, геомэдээлэл, сургалтын төвийн эрдэмтэд ЦЭГ-ын мэргэжилтнүүдтэй хамтран боловсруулсныг 2019 оны 10 дугаар сард олон нийтэд танилцуулан, нийтийн хүртээл болгосон. Тус зөвлөмжийн дагуу ураны 2, газрын ховор элементийн 2 ордыг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн нөөцийг улсын нөөцийн санд бүртгэсэн. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 21 | | 10. Цацраг идэвхт ашигт малтмал болон газрын ховор элементийн хайгуул, геологийн судалгааны ажлыг гүйцэтгэх | 2016 - 2020 | УУХҮЯ /ГУУБХЗГ/ | | Хувийн хэвшилийн хөрөнгө оруулалт 20,000.0 Цацраг идэвхт ашигт малтмал, газрын ховор элементийн батлагдсан нөөц нэмэгдэх | Цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа аж ахуйн нэгжүүдийн 2017 оны хайгуулын ажлын зардал, 2018 оны төлөвлөгөөний талаарх мэдээлэлийг АМГТГ-аас гаргуулан авсан ба ирүүлсэн мэдээллийг нягтлан үзэхэд тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд 2017 онд 16.9 тэрбум төгрөгийг хайгуулын ажилд зарцуулсан бөгөөд энэ нь 2016 онтой (13.1 тэрбум төгрөг) харьцуулахад 29 хувиар нэмэгдсэн боловч 2012 оны дүнтэй харьцуулахад 2.3 дахин буурсан үзүүлэлттэй байна. Цацраг идэвхт ашигт малтмалын нөөцийн мэдээг хагас жил тутам Цөмийн Энергийн комиссын ажлын албанд хүргүүлж байна.<br>-“Монгол орны газрын ховор элементийн металлогени, түүний хэтийн төлөвийн судалгаа” 2013-2014 онд улсын төсвийн хөрөнгөөр сэдэвчилсэн судалгааны ажил хийгдэж тайлан 2016 онд хүлээн авсан.<br>-“Лукрий” ХХК-ийн Улаан нуур ураны ордын үр дүнгийн тайланг ЭБМЗ-д хэлэлцүүлэхэд бэлтгэсэн байна.<br>-“Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутагт орших Зөөвч овоогийн ураны ордод 2012-2018 онуудад гүйцэтгэсэн нарийвчилсан хайгуулын ажлын үр дүнгийн тайлан” (Ордын нөөц 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар) дахь Зөөвч овоогийн ураны ордын геологийн нөөцийг бодитой болон боломжтой (B+C) зэрэглэлээр 233,85 г/тн эквивалент ураны дундаж агуулга бүхий 93,290.63 тн, үүнээс бодитой (B) зэрэглэлээр 233,85 г/тн эквивалент ураны дундаж агуулга бүхий 41,636.89 тн, боломжтой (C) зэрэглэлээр 227,54 г/тн эквивалент ураны дундаж агуулга бүхий 51,653.74тн-оор хүлээн авсан.<br>-Архангай аймгийн Өндөр-Улаан сумын нутагт орших “Далт” нэртэй ураны ордын XV-005359 тоот тусгай зөвшөөрлийн талбайд 2010-2014 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайлан” дахь /2018 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар/ Далт нэртэй ураны ордын нөөцийг бодитой (B) зэрэглэлээр 2,202.67 тн, боломжтой (C) зэрэглэлээр 13,315.44 тн, ордын хэмжээнд нийт бодитой болон боломжтой (B+C) зэрэглэлээр 15,518.11 тн-оор хүлээн авсан.<br>-Увс аймгийн Завхан сумын нутагт орших “Улаан Дэл” нэртэй циркони-газрын ховор элементүүдийн ордод 2010-2017 онуудад гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайлан (ордын нөөц 2017 оны 10-р сарын 01-ний өдрийн байдлаар) дахь хүдрийн хэсгүүдэд боломжтой (C) зэрэглэлээр 82,130.4тн, хүдэрт ∑TREO 124,786.9кг, $ZrO_2$ 238,931.4кг, $Nb_2O_5$ 34,834.7кг-аар хүлээн авсан.<br>-Хэнтий аймгийн Биндэр, Өмнөдэлгэр сумдын нутагт орших Хар бургаст XV-010256, Цагаанчулуут XV-013060 тоот хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд орших “Цагаанчулуут, Хар бургастай” нэртэй монацитын шороон ордын нөөцийг XV-010256 тоот хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах “Хар бургастай”-н доод хэсэгт /2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар/ боломжтой (C) зэрэглэлээр монацитыг 29.55 тн, нийт “Цагаанчулуут, Хар бургастай” нэртэй монацитын шороон ордын боломжтой (C) зэрэглэлийн нөөцийг 274.55 тн-оор, монацит дахь уран /0.46%/-1.24 тн, торийн хоёрдогч исэл $Th_2O_3$ /7.4%/-20.27 тн, церийн хоёрдогч исэл $Ce_2O_3$ /27.2%/-74.62 тн-оор, энэхүү дүгнэлтийн хавсралт хүснэгт 1-д заасны дагуу хүлээн тус тус хүлээн авч Уран болон газрын ховор элементийн нөөцийг нэмэгдүүлсэн. Ураны нөөц 66 мян/тн орчим нэмэгдсэн байна. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 22 | 2.60.Олон улсын жишгийн дагуу Үндэсний геологийн алба, Үндэсний геомэдээллийн санг байгуулан, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулна. | 1. Үндэсний геологийн алба байгуулахдаа хууль, эрх зүй, эдийн засгийн үр өгөөж, гадаад улсуудын ижил төстэй байгууллагуудын талаар иж бүрэн судалгаа хийх, санал, дүгнэлт боловсруулж, ЗГ, УИХ-аар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулах, үйл ажиллагааг эхлүүлэх | 2017 - 2020 | УУХҮЯ /ГУУБХЗГ/ | Батлагдсан-229.2 Гүйцэтгэл - 0.0 Санхүүжилт – 0.0 | Алба байгуулах санал, төслийг боловсруулан холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх | Үндэсний геологийн алба байгуулах ажлын хүрээнд АНУ–USGS, БНСУ- KIGAM, Англи-British Geological Survey, Хятад-Chinese Geological survey, Норвеги-The Norwegian geological survey (NGU), Финлянд-The Geological Survey of Finland (GTK), Канад-The Geological Survey of Canada, ОХУ-VSEGEI, Энэтхэг- Geological Survey of India (GSI), Австрали-The Geological Survey of Western Australia зэрэг гадаад орнуудын геологийн албадын бүтэц, үйл ажиллагааны зохион байгуулалт, хууль эрх зүйн орчныг судалж харьцуулсан дүгнэлт хийсэн.<br>Олон Улсын жишгийн дагуу "МУ-ын Үндэсний Геологийн Алба"-ыг байгуулах хууль, эрх зүйн үндэслэлийн талаар судалгаа хийж, судалгааны ажлуудын үр дүнд тулгуурлан албаны бүтэц, схемийг боловсруулж, үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулалтын талаар дүгнэлт гаргаж, танилцуулга бэлтгэсэн. Салбар хоорондын уялдааг хангах зорилгоор БОАЖЯ (2018.04.09-ний 01/2151 тоот), ЗТХЯ (2018.04.09-ний 02/1547 тоот), БСШУСЯ (2018.04.03-ны 1а/3035 тоот), БХБЯ (2014.04.16-ны 01/1346 тоот)-аас албаны үйл ажиллагаа, зохион байгуулалтын талаар санал авсан. МУ-ын нийгэм, эдийн засгийг 2019 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлд тусгагдсан Үндэсний геологийн албаны хөрөнгө оруулалтын хэмжээг тооцоолон холбогдох газарт хүргүүлсэн.<br>-Үндэсний геологийн алба байгуулах асуудлыг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр тогтоолын төсөл, танилцуулгыг бэлтгэн яамдаас 2018.09.12-ны өдрийн 01/2440 тоот албан бичгээр санал авсан. СЯ-ны зүгээс төсөвт хүндрэл учруулахгүй байх хувилбарыг боловсруулах санал /чиглэл/ өгсний дагуу төсөвт нэмэлт зардал үүсгэхгүйгээр бүтэц, орон тоо, бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулах санал бэлтгэн СЯ-нд 2018.12.05-ны өдрийн 01/3231 тоот албан бичгээр хүргүүлсэн. Алба байгуулах асуудлыг ЗГ-ын хуралдаанд танилцуулахаар 2019.05.10-ны өдрийн 01/1396 тоот албан бичгээр холбогдох материалыг хүргүүлсэн.<br>Үндэсний геологийн алба байгуулах тухай танилцуулга, ЗГ-ын хуралдааны тэмдэглэлийн төсөл, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний зарим байгууллагуудын үйл ажиллагааг нэгтгэн зохицуулахаар өөрчлөн зохион байгуулах байгууллагуудын танилцуулга, УИХ-ын тогтоолын төсөл, төслийн үр нөлөөг үнэлэх судалгааны тайлан, чиг үүргийн ангиллын тайлан болон холбогдох бусад материалыг ЗГХЭГ-т 2019 оны 01/2870 тоот албан бичгээр хүргүүлсэн. ЗГ-ын 10 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаар тус асуудлыг хэлэлцэн дэмжиж, Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу холбогдох арга хэмжээг авч УИХ-д өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн. Асуудлыг УИХ-д өргөн мэдүүлэхээр холбогдох хууль, тогтоомжийн дагуу СЯ, ХЗДХЯ-аас зөвшөөрөл, ҮХГ, ТАЗ-өөс санал авч, тогтоолын үзэл баримтлалыг батлуулсан.<br>Үндэсний геологийн алба байгуулах тухай УИХ-ын тогтоолын төслийг УИХ-д 2019 оны 12-р сард өргөн барьсан бөгөөд 2020 оны 1-р сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн УИХ-ын 12 дугаар тогтоолоор батлагдсан. УИХ-ын тогтоолын дагуу "Засгийн газрын агентлагийн талаар авах арга хэмжээний тухай" Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ЗГХЭГ-т 2020.03.16-ны өдрийн 01/703 тоот албан бичгээр хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 23 | | 2. Үндэсний геомэдээллийн санг баяжуулах, нэгдсэн загварт оруулах, мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааны журмыг боловсруулах, түгээх үйл ажиллагааг боловсронгуй болгох | 2016 - 2020 | УУХҮЯ /ГУУБХЗГ/ | Батлагдсан -951.6 Гүйцэтгэл – 314.8 Санхүүжилт – 314.83 | Геологийн судалгааны ажлын үр дүнг нэгтгэх төсөл дуусч, хэрэглэгчид үзүүлэх үйлчилгээ түргэн шуурхай болох | МУ-ын ЗГ-ын 2019.05.01-ний өдрийн хуралдаанаар “Үндэсний геомэдээллийн сан” үндэсний хөтөлбөрийн төслийг хэлэлцүүлэн 177 дугаар тогтоолоор батлуулсан. Тогтоолын дагуу хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг УУХҮЯ, БОАЖЯ, ҮХГ, АМГТГ, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, мэргэжлийн холбоод гэсэн бүрэлдэхүүнтэйгээр ТНБД-ын 2019 оны А/95 дугаар тушаалаар байгуулагдан ажиллаж үйл ажиллагааны төлөвлөгөөг УУХҮС-ын 2019 оны А/216 дугаар тушаалаар батлуулсан.<br>Төлөвлөгөөний дагуу хийсэн томоохон ажлууд нь: **1.** АМГТГ-т 2000-2010 оны хооронд үүсгэсэн ба одоог хүртэл баяжуулагдан байгаа өөр хоорондоо холбоогүй геомэдээллийн 21 төрлийн сангуудад нарийвчилсан шинжилгээг гүйцэтгэж шинээр бий болох геомэдээллийн сангийн бүтэц ба мэдээлэл оруулах ажлын урсгалыг багтаасан мэдээллийн системийн загварын төслийг боловсруулсан, **2.** 1:500000-ны геологийн зургийн нэгдсэн сан үүсгэх ажлын хүрээнд МУ-ын хэмжээнд 1:500000-ны хавтгай (37) тус бүрээр хийгдсэн геологийн зургуудыг нэгтгэн, нэгдсэн нэг зураг үүсгэх, мөн тус зургийг дагалдах таних тэмдэг хийсэн. Уг ажилтай холбогдуулан нийт 42400 полигоны хүснэгтэн мэдээллийг (мега бүс, тектоник бүс, формац, бүрдлийн нэр болон чулуулгийн тодорхойлолт) таних тэмдэг болон бусад мэдээлэлд тулгуурлан тодорхойлж, монгол, англи хэл дээр бүрдүүлсэн, **3.** ҮГМС-ийн портал болох www.mris.mn нүүр хуудасны туршилтын загварыг боловсруулж, холбогдох саналыг авч, сайжруулалт хийж, АМГТГ-ын веб сервер дээр www.mris.mn нууцлал хамгаалал (SSL certificate) хийсэн. Веб сервэр тохируулга хийсэн, **4.** “МонГеоКат” системд оруулсан 223 тайлангийн метадатаны орон зайн холболтыг WebGIS системд суурилсан геологийн мэдээллийн системд оруулсан http://webgis.mris.mn/#/, **5.**АМГТГ-ын мэдээллийн технологийн аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл байдлын дүн шинжилгээг “ISO 27001” стандартын дагуу хийж, холбогдох арга хэмжээ авах тухай санал, зөвлөмж боловсруулсан. Мөн түүнчлэн мэдээллийн аюулгүй байдлыг хангах төлөвлөгөөг боловсруулсан, **6.** АМГТГ-ын ЭБМТТ-ийн уншлагын танхимд цахим хэлбэрээр тайлан, материалтай танилцах боломж бүрдүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж болох автоматжуулсан сканнер, номын сканнер, проектор, компьютер зэрэг тоног төхөөрөмжийн худалдан авсан, **7.**Баримт бичгийн менежментийн системийг (DMS) хөгжүүлж эхлээд байна. Тус систем нь геологийн архивт байгаа тайлан, мэдээллийг татан авах, сканнердах, оптик тэмдэгт мэдрэх, хадгалах, бүртгэх, удирдах үүргүүдтэй байна.<br>- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд Үндэсний геомэдээллийн санг Интрузив, эффузив, үнэмлэхүй насны мэдээллийг нэгтгэх, Давхарга зүй, палеонтологийн олдвор, горизонтын тулгуур зүсэлтийн мэдээллийг нэгтгэх, хээрийн баримт материал, үр дүнгийн тайлангийн мэдээллийг цахимаар хүлээх авах, сан бүрдүүлэх аргачлал, үлгэрчилсэн загвар боловсруулах, багажны хэмжилтийн утгыг нарийвчлан гаргах, бүх төрлийн масштабын геологийн зураг, давхаргын мэдээллийн сан бүрдүүлэх, баяжуулах, нэгдсэн загварт оруулах зорилгоор Геомэдээлэл-2019 төслийг 2019 оноос хэрэгжүүлж эхэлсэн. 2020 онд төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын А/254 дүгээр тушаалаар батлуулсан. Төслийн ажлын хэмжээ, арга аргачлалыг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн УУХҮС-ын 2020 оны А/129 дүгээр тушаалаар баталж суурин боловсруулалтын ажлыг эхлүүлээд байна. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 24 | 2.61.Геологи, уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтыг татах эрх зүйн таатай орчинг бүрдүүлж, харилцан үр ашигтай төсөл, хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлнэ. | 1. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах | 2017 - 2018 | УУХҮЯ /ГУУБХЗГ/ | | Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлж, батлуулах | АМТХ-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд салбарын мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгжүүд, судлаачдын төлөөллүүдийн дунд 2018.06.08-ны өдөр хэлэлцүүлэг зохион байгуулж, саналуудыг авч нэгтгэсэн. Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, үзэл баримтлалыг боловсруулж, “Хууль тогтоомжийн тухай” хуулийн дагуу АМТХ-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн судалгааны тайланг бэлтгэсэн. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох асуудлаар нэмэлт өөрчлөлт оруулах төсөл, холбогдох материалыг боловсруулсан. Эрдэс баялгийн салбарын хуулиудын хийдэл, зөрчил, давхардлыг арилгах зорилгоор холбогдох хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг ХЗДХЯ-тай хамтран боловсруулж ЗГ-ын 2019.06.06-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжих тухай тэмдэглэл гарсан. Тэмдэглэлийн дагуу АМТХ, ГТТХ, ГТБТХ болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг бэлтгэн 2018.11.24-ний өдрийн ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлсэн. АМТХ нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, УИХ-ын 2019.03.26-ны өдрийн хуралдаанаар тус тус хэлэлцүүлж батлуулсан. АМТХ-ийн 47 дугаар зүйлийн зарим хэсэг, заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай асуудлыг Үндсэн Хуулийн Цэцийн Их суудлын хуралдаанаар 2019.10.30-ны өдөр хэлэлцэж, АМТХ-ийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийн “Ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан хуулийн этгээд ... нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байх ба ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан бүх төрлийн ашигт малтмалын борлуулалтын үнэлгээнээс тооцож улсын төсөвт төлнө.” гэсэн заалт болон мөн зүйлийн 47.3 дахь хэсгийн 47.3.1, 47.3.2 дахь заалт, 47.4 дэх хэсэг, 47.5 дахь хэсгийн 47.5.11, 47.5.12, 47.5.13 дахь заалт нь МУ-ын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Төр нь ... аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэснийг тус тус зөрчсөн байх тул хүчингүй болгох тухай 04 тоот тогтоолыг гаргасан. Иймд ТЕХ-ийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт "Татвар ногдох зүйлд орлого, эд хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээ, тодорхой эрх, газар, түүний хэвлий, байгалийн баялаг, ашигт малтмалын нөөц, агаар, хөрс, усны бохирдол хамаарна" гэснийг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй нөхцөл байдлыг үүссэн. Иймд дээр дурьдсан нөхцөл байдлыг шийдвэрлэх үүднээс ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч нь ямар тохиодолд хэдий хэмжээний ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөх харилцааг зохицуулсан АМТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан Улсын Их хурлын 2019.11.22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулсан. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт орсонтой уялдуулан АМТХ болон холбогдох багц хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд геологийн салбартай холбогдох нэмэлт өөрчлөлтийн саналыг боловсруулан хуулийн хэлтэст хүргүүлсэн. УУХҮС-ын 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/232 дугаар тушаалаар хуулийн төслийн шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулж, ЗГХЭГ-аас, үндсэн хуулинд орсон нэмэлт, өөрчлөлтийг судалж, холбогдох | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 25 | 2. Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулах | 2018 | УУХҮЯ /ГУУБХЗГ/ | | Хуулийн төслийг боловсруулж, УИХ-аар батлуулах | Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай бие даасан хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019.05.02-ны өдрийн А/82 дугаар тушаалаар байгуулсны дагуу ажлын хэсгийн хурлыг зохион байгуулж, гишүүдийн ажиллах нарийвчилсан төлөвлөгөөг хэлэлцүүлсэн. Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хуулийн төсөл боловсруулах шатанд хийгдэх хуулийн төслийн хэрэгцээ шаардлагын тандан судалгаа, олон улсын ижил төстэй эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа, хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, хууль хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо зэрэг судалгааны ажлуудыг Нээлттэй нийгэм форум төрийн бус байгууллагын санхүүгийн дэмжлэгтэйгээр хийж гүйцэтгэсэн. Үүний дагуу “Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хууль”-ийн төслийн үзэл баримтлалыг боловсруулж Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдаар батлуулсан.<br>Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг ажлын хэсгийн хүрээнд боловсруулж яамны цахим сайтад байршуулах, улмаар хэлэлцүүлэг зохион байгуулахаар ажиллаж байна. | 70 |
| 26 | 3. Газрын хэвлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах | 2019 | УУХҮЯ /ГУУБХЗГ/ | | | Газрын хэвлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлал, хуулийн төсөл боловсруулах ажлыг УУХҮЯ-ны ТНБД-ын 2016 оны Б/113 дугаар тушаалаар байгуулан ажиллуулсан. Ажлын хэсгийн гишүүд өөрчлөгдсөнтэй холбогдуулан УУХҮС-ын 2018 оны А/209 дүгээр тушаалаар шинэчилэн байгуулсан. Ажлын хэсэг нь “Газрын хэвлийн тухай хууль”-ийг шинэчлэн найруулах ажлын хүрээнд Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр /АМЕП/-ийн багийнхантай хамтран хуулийн төсөл, үзэл баримтлалын төслийг шинэчлэн боловсруулж, тандан судалгаа хийж гүйцэтгэн эхний хувилбарыг боловсруулсан. УУХҮЯ-д бүтцийн өөрчлөлт хийгдсэнтэй уялдуулан Ажлын хэсгийг шинэчилэн байгуулах бэлтгэл ажлыг хийж байна. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт орсонтой уялдуулан хуулийн үйлчлэх хүрээ болон бусад газрын хэвлийтэй холбоотой харилцааг зохицуулж буй хуулиудтай уялдуулах зорилгоор хуулийн төслийн хэрэгцээ шаардлагын судалгааг хийж байна. | 70 |
| 27 | 4. Эдийн засгийн үр ашигтай төслүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх | 2016 - 2020 | УУХҮЯ /ГУУБХЗГ/ | | Бэлэн болсон 20-иос доошгүй уурхай, уулын үйлдвэрийг ашиглалтад оруулах | Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.61.4, 2.69.6-д заасан “Эдийн засгийн үр ашигтай төслүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх” хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн А/16 дугаар тушаалаар Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг ашиглатад хүлээн авах журмыг баталж, 2020 онд үйл ажиллагаа эхлүүлэх бэлтгэл ажлаа хангасан 11 уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг ашиглалтад хүлээн авч 1500 орчим ажлын байрыг шинээр бий болгосон. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 28 | 5. Гадаад орнуудтай хамтарсан геологийн судалгааны ажлын төслийг хэрэгжүүлэх, үр дүнгийн тайланг хүлээн авах | 2017 - 2020 | УУХҮЯ /ГУУБХЗГ/ | Батлагдсан -228.3 Гүйцэтгэл – 82.9 Санхүүжилт – 82.9 | Улсын төсөв 200.0 Хамтран хэрэгжүүлсэн төслүүдийн үр дүнг хүлээн авах | МУ, БНХАУ, БНСУ, ОХУ, БНКазУ-ын хамтарсан “Хойд, төв, зүүн Азийн гүний геологийн процесс ба металлогени” төслийн 3-р үе шатны судалгааны ажлын үр дүнг ЭБМЗ-ийн 2017 оны УТХ-10-02 дугаар дүгнэлтйг үндэслэн УУХҮС-ын 2018 оны А/16 дугаар тушаалаар хүлээн авсан. Хамтарсан төслийн 4-р шатны ажлын 2020 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын 2019 оны А/254 дүгээр тушаалаар батлуулсан. Төслийн 2020 онд гүйцэтгэх хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлал, төсвийн тодотголыг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн УУХҮС-ынА/124 дүгээр тушаалаар батлуулсан. Төслийн 4-р шат буюу "Их Алтай"-н төслийн хэмжээнд Монголын тал Монгол Алтай нуруунд судалгааны ажлыг хэрэгжүүлж байгаа бөгөөд суурин боловсруулалтын ажил эхлээд байна. | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 29 | | 6. Хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх талаар гадаад орнуудаас ирүүлсэн саналыг судалж, харилцан үр ашигтай төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 2017 - 2020 | УУХҮЯ /ГУУБХЗГ/ | | Улсын төсөв 1,500.0 Харилцан үр ашигтай төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх | ОХУ-ын Росгеолфонд-д хадгалагдаж байгаа Монгол Улсын нутаг дэвсгэрт 1960-1990 оны хооронд хийгдсэн геологи-геофизикийн тайлангуудын хуулбарыг Монголын талд шилжүүлэн авах ажил амжилттай хэрэгжиж, эхний ээлжний олон нийтэд нээлттэй 70 тайланг цахим хуулбарт хөрвүүлэн 3-р сарын 21-ний өдөр авсан. Эдгээр тайланг 4-р сарын 06-ны өдөр 70 ширхэг цахим тайлан, 12 хуудас холбогдох материалын хамт АМГТГ-т хүлээлгэн өгсөн.<br>- ОХУ-ын “Росгеологи”, Монгол Улсын АМГТГ-ын геологийн салбарт хамтран ажиллах талаар хэлэлцээр 2019 оны 09 дүгээр сард байгуулагдсан. Энэ ажлын хүрээнд хэрэгжиж болох ажлын санал солилцсон. Энэ саналуудыг судалж 12 дугаар сард Монгол улсын ерөнхий сайдын ажлын айлчлалын үеэр “Росгеологи” нийгэмлэгийн удирдлагатай уулзаж хамтран ажиллах талаарх санал солилцсон.<br>- Ашигт малтмалын тухайн төрөл тус бүрээр эрэл, хайгуулын ажлыг явуулах аргачилсан зөвлөмж боловсруулах ажлын хүрээнд Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөрийн санхүүжилтээр алтны үндсэн болон шороон орд, төмөр, хайлуур жонш, газрын тос гэсэн 5 төрлийн ашигт малтмалын эрэл, хайгуулын ажилд хэрэглэх аргачилсан зөвлөмж боловсруулж, 2019.04.05-ны өдрийн ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн батлуулсан.<br>- МУ-ын олборлох салбарын менежментийг бэхжүүлэх Канадын СЕСМИМ төсөлтэй хамтран 1 ашигт малтмалын төрлөөр уг ажлыг эхлүүлсэн бөгөөд зааврын төслийг боловсруулж, 7 дугаар сард ЭБМЗ-өөр хэлэлцүүлсэн. УУХҮС-ын 2019 оны А/193 дугаар тушаалаар Аргачилсан зөвлөмжийг хүлээн авсан. Ингэснээр Австрали-Монголын Эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр болон СЕСМИМ төслийн боловсруулсан аргачилсан зөвлөмжийг 1000% хэвлэн геологичдын хүртээл болгосон.<br>- Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын ЗГ хоорондын комиссын 22 дугаар хуралдаанаар АМГТГ нь Росгеология хувьцаат нийгэмлэгтэй хамтын ажиллагааг өргөжүүлэх боломжтойг талууд дэмжсэн тул 9 дүгээр сард хамтын ажиллагааны санамж бичгийг байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.<br>- ОХУ-ын Ерөнхийлөгч В.В. Путины Монгол Улсад айлчлах үеэр Монгол Улсын Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэн болон ОХУ-ын Росгеологи хувьцаат нийгэмлэгийн Ерөнхий захирал С.Н.Горьков нар Хамтран ажиллах санамж бичигт 2019 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр гарын үсэг зурсан. Хамтын ажиллагааны гол чиглэл нь байгалийн баялгийг зохистой хөгжүүлэхэд чиглэж, МУ-ын нутаг дэвсгэрт геологийн судалгааны асуудлаар гүйцэтгэх хамтын ажиллагааны үндэс болох юм. Санамж бичгийн хүрээнд АМГТГ-ын орлогч дарга М.Энхжаргалаар ахлуулсан ажлын хэсэг АМГТГ-ын даргын тушаалаар байгуулагдан төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 30 | 2.62.Уул уурхайн үйлдвэрлэл дэх төрийн оролцоог зохистой хэмжээнд байлгаж, Кадастрын бүртгэлийн системийг боловсронгуй болгож, тусгай зөвшөөрөл олгох үйлчилгээг хөнгөн шуурхай болгоно. | 1. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг хялбаршуулах талаар судалгаа хийж, хэрэглэгчдэд ойлгомжтой байдлаар тусгай зөвшөөрөл олгох, мэдээллийг ил тод, нээлттэй түгээх аргачлалын санал боловсруулах | 2017 - 2018 | УУХҮЯ /ГУУБХЗГ/ | | Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох үйлчилгээ хялбар, шуурхай болох, олон нийтэд ойлгомжтой болох | Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журмыг боловсруулан УУХҮС-ын 2018 оны 2-р сарын 13-ны өдрийн А/28 дугаар тушаалаар батлуулан захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2018 оны 2-р сарын 21-ний өдрийн 3863 дугаарт бүртгүүлсэн.<br>- Улсын Их Хурлын 2017 оны 11-р сарын 10-ны өдрийн хуралдаанаар АМТХ-ийн 17 дугаар зүйлийг өөрчлөн найруулан баталсан. Ашигт малтмалын тухай хуулийн энэхүү нэмэлт өөрчлөлтийн дагуу Засгийн газрын 2014 оны 239, 2015 оны 511, 2017 оны 37, 234 дүгээр тогтоолоор батлагдсан сонгон шалгаруулалтаар олгох 13.62 сая гектар талбайгаас хуулиар хязгаарласан, хориглосон 4.07 сая гектар талбайг хасаж, тусгай зөвшөөрөл олгох боломжтой 8.68 сая гектар талбайг ялган 2018 оны 1-р сарын 29-ний өдрөөс эхлэн хуульд заасан 45 хоногийн хугацаанд орон нутгаас санал авсны үндсэн дээр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 4 дүгээр сарын 20-ны өдрийн 01/1086 тоот албан бичгээр хүргүүлсэн. Засгийн газрын хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцээд МУ-ын Ерөнхий сайдаас БОАЖЯ, ХХААХҮЯ-ны саналуудыг судалж, тусгах чиглэл өгсний дагуу дээрх 2 яамтай хамтран ажиллаж, нэгдсэн санал бэлтгэсэн. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох талбайн солбицлын тухай нэгдсэн саналыг Засгийн газрын 2018 оны 8-р сарын 08-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн "Талбайн солбицол тогтоох тухай" 243 дугаар тогтоолыг гаргасан. Уг тогтоолоор нийт 237,580 солбицол бүхий 8,489,065.45 гектар талбайг сонгон шалгаруулалтад хамруулахаар тогтоон нийтэд зарлахаар шийдвэрлэсэн. Хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох ажил 2018 оны 8-р сарын 22-оос эхлэсэн бөгөөд оны эцсийн байдлаар 6 багцаар 60-н талбайд 511,189.89 га-д хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт зарласан. Үүнээс 217 мян.га талбайд 27 хайгуулын тусгай зөвшөөрөл олгож улсын төсөвт бодитоор 13,8 тэрбум төгрөг төвлөрүүлээд байна. Хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох ажил 2019.01.07-ноос хойш 2019.06.01-нийг хүртэл сонгон шалгаруулалтын 126 багц мэдээлэл тарааж, 92 аж ахуйн нэгжийн 98 санал хүлээн авч бүртгэсэн. 2018 оны 12 дугаар сарын сүүлээр СШ-28, СШ-30 кодтой сонгон шалгаруулалтанд шалгарч үнийн саналын зөрүүг 2019 оны 01 дүгээр сард төлсөн 9 аж ахуйн нэгжид 2019 онд шинээр хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон. 2019 оны эхний хагаст зарлагдсан 7 багц сонгон шалгаруулалтаас санал нээж үнэлсэн 5 багц сонгон шалгаруулалтад шалгарсан 29 аж ахуйн нэгжүүдээс СШ-31, СШ-32, СШ-33-т шалгарсан 19 аж ахуйн нэгж нь үнийн саналын зөрүүг төлж хайгуулын тусгай зөвшөөрөл нь олгогдсон. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журмын дагуу 2019 онд нийт 10 удаа сонгон шалгаруулалт зарлан 54 талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл олгож улсын төсөвт 15.7 тэрбум гаруй төгрөг төвлөрүүлээд байна. Сонгон шалгаруулалтын явцад ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журамд нэмэлт, өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага үүссэн тул 2019 оны 12 дугаар сард Засгийн газрын хуралдаанаар танилцуулан, нэмэлт өөрчлөлт оруулах эрх авсан. Уг ажлын хүрээнд сонгон шалгаруулалтын журмын нэмэлт өөрчлөлтийн төслийг хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу боловсруулан 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/16 дугаар тушаалаар Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журамд хавсралтад дурдсан нэмэлт, өөрчлөлтийг оруулан Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн бүртгүүлсэн. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 31 | 2.63.Газрын тосны болон уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын ажлыг эрчимжүүлж, нөөцийг өсгөнө. | 2. Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах | 2018 - 2019 | УУХҮЯ /ХҮГТБХЗГ/ | | Холбогдох байгууллагууд тай хамтарсан ажлын хэсгийг байгуулж, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судалж, боловсруулах | Эрдэс баялгийн салбарт үйлчилж буй багц хуулиудын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах ХЗДХС/УУХҮС-ын 2017.12.13-ны өдрийн хамтарсан А/298/А/240 тоот тушаалаар байгуулсан ажлын хэсгийн ажлын хүрээнд "Газрын тосны тухай" хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгахаар ажиллаж, мэдээллээр ханган, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Мөн газрын тосны асуудлаар татварын хөнгөлөлтийн жилийг 5 жилээр нэмэгдүүлэх, орон нутагт орох өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор НӨАТ, гаалийн албан татварын тухай хууль, төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах саналаа Сангийн яаманд 2018 оын 5-р сарын 14-ны өдрийн 01/1327 тоотор хүргүүлсэн. Газрын тосны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг томъёоллыг бэлдэж, Ажлын хэсэгт тухай бүр танилцуулж, ЗГ-ын 2018 оны 6-р сарын 6-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Мөн газрын тосны тухай хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах ажлын хэсэгт ажиллаж, мэдээллээр ханган, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Газрын тосны асуудлаар татварын хөнгөлөлтийн жилийг 5 жилээр нэмэгдүүлэх, орон нутагт орох өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор НӨАТ, Гаалийн албан татварын тухай хууль, Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг Сангийн яаманд 2018.05.14-ний өдрийн 01/1327 тоот албан бичгээр хүргүүлсэн. Мөн 2018.10.24-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар Ашигт малтмалын тухай, Газрын тосны тухай, Газрын тосны бүтээгдэхүүний тухай болон бусад хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцээд УИХ-д өргөн мэдүүлсэн. УИХ-ын 2019.05.26-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлсэн боловч гишүүдийн олонхийн саналаар хуулийн төсөл буцаагдсан. Энэхүү хуулийн төсөл, үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд дахин ЗГ-ын хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцүүлэхээр ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 32 | 3. Газрын тосны салбарын хөрөнгө оруулалтын болон эдийн засаг, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх | 2016 - 2019 | УУХҮЯ /ХҮГТБХЗГ/ | | Хөрөнгө оруулагч нарт таатай эдийн засаг, эрх зүйн орчин бүрдүүлэх | Бүтээгдэхүүн хуваах гэрээг шинэчлэх тухай Засгийн газрын 2016 оны 130 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдөр баталсан Газрын тосны тухай хууль батлагдахаас өмнө байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийн үндсэн нөхцөлийг өөрчлөхгүйгээр Засгийн газрын 2015 оны 104 дүгээр тогтоолоор баталсан Бүтээгдэхүүн хуваах гэрээний загварт нийцүүлэн хэлэлцээр хийж шинэчлэх үүрэг бүхий ажлын хэсгийг сайдын 2016 оны А/57, 2018 оны А/12 дугаар тушаалаар тус тус байгуулж ажиллав. Газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулж буй компаниудын хувьд Ажлын хэсэг нийт 10 гэрээлэгчтэй уулзалт хэлэлцээр хийсний дүнд хайгуулын үе шатанд хэрэгжиж буй нийт 15 Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдээс 4 гэрээг шинэчлэн байгуулж, 3 гэрээг шинэчлэн байгуулахад бэлэн болгож, 3 гэрээг шинэчлэхээр хэлэлцээ хийж байна. БХГ-нүүдийг шинэчлэх ажлын хэсгийг УУХҮСайдын 2018.01.17-ны өдрийн А/12 дугаар тушаалаар байгуулж, хэлэлцээр хийх хуралдаанд оролцон ажлын хэсгийг мэдээллээр хангаж ажилласан. БХГ-нүүдийг 2015 оны Засгийн газрын 104-р тогтоолоор батлагдсан загварт нийцүүлж шинэчлэх ажлын хүрээнд газрын тосны хайгуулын Богд IV, Онги V талбайд БХГ байгуулсан "Капкорп Монголиа" ХХК-ийн, газрын тосны хайгуулын Матад XX талбайд БХГ байгуулсан "Петро Матад" ХХК-ийн, газрын тосны хайгуулын Баянтүмэн XVII талбайд БХГ байгуулсан "Магнай трейд" ХХК-ийн гэрээг тус тус шинэчлэн байгуулсан. Түүнчлэн:<br>-Нялга XVI талбайд 2018-08-27нд шинэчлэн байгуулсан<br>-Богд IV, Онги V талбайд 2018-06-05-нд шинэчлэн байгуулсан<br>-Баянтүмэн XVII талбайд 2018-06-08-нд шинэчлэн байгуулсан<br>-Матад XX талбайд 2018-06-08 нд шинэчлэн байгуулсан<br>-БХГ-ний хэрэгжилтийн талаар ЗГ-ын 2018.05.02-ны өдрийн болон 2018.10.03-ны өдрийн хуралдаанд тус тус танилцуулсан. ЗГ-ын 41 дүгээр тэмдэглэлийг гаргуулсан.<br>"Газрын тосны бүртгэл тооцооны журам"-ын төсөлд яамдаас санал авч нэгтгэн, ирүүлсэн саналыг журмын төсөлд тусган эцэслэн боловсруулж ЗГХЭГ-т хүргүүлсэн ба Засгийн газрын 2019.05.01-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн, 178 дугаар тогтоолоор баталсан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 33 | | 4. Газрын тосны ордын ашиглалтыг эрчимжүүлж, олборлолтыг урт хугацаанд тогтвортой хадгалж, | 2016 - 2020 | УУХҮЯ /ХҮГТБХЗГ/ | | Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 1,000,000.0 Тухайн жилийн | Зүүн бүсийн уул уурхай, газрын тосны ашиглалтын үйл ажиллагаанд шаардлагатай эрчим хүчийг дотоод, гадаад эх үүсвэрээс хангах, нөөц эх үүсвэр бий болгох боломжийг судалж, дүгнэлт гаргах зорилгоор Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд болон Эрчим хүчний сайдын хамтарсан А/58/36 дугаар тушаалаар ажлын хэсэг 2018.03.12-ны өдөр байгуулагдсан. Үүний дагуу ажлын хэсгийн гишүүд Дорнод, Сүхбаатар аймгуудад байрлах Шинь Шинь ХХК, Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК, Петрочайна Дачин Тамсаг ХХК, Цайрт минерал ХХК болон Эм эл цахиурт овоо ХХК-иудад 2018.04.02-08-ны өдрүүдэд ажиллаж, тус ажлын үр дүнд гарсан дүгнэлтийг ажлын хэсгийн 2018 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн хуралд танилцуулж, ажлын хэсгийн гишүүдээр хэлэлцүүлэн дүгнэлтийг гаргуулав. Үүний дагуу БНХАУ-аас Тамсаг XXI талбай хүртэл 18 км цахилгаан дамжуулах шугам татах нь зүйтэй гэсэн дүгнэлт гаргасан. Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг УУХҮЯ-ны Удирдлагын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, 2018.10.18-ны өдөр 07 дугаар тэмдэглэл гарсан. Мөн газрын тосны асуудлаар татварын хөнгөлөлтийн жилийг 5 жилээр нэмэгдүүлэх, орон нутагт орох өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор НӨАТ, гаалийн албан татварын тухай хууль, төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах саналаа Сангийн яаманд 2018.05.14-ны өдрийн 01/1327 тоот албан бичгээр хүргүүлсэн. Газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд Үндэсний Аудитын газар болон МХЕГ-аас хийсэн шалгалтын дагуу өгсөн үүрэг даалгаварын биелэлтэд хяналт тавьж ажиллаж байна. Мөн Уул уурхайн сайдын Дорнод аймагт ажиллахтай холбогдуулан 2018.05.02-07-ны өдрүүдэд Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайд томилолтоор ажиллаж, үүрэг даалгаварын биелэлтэд хяналт тавьж ажилласан. Зүүн бүсийн уул уурхай, газрын тосны ашиглалтын үйл ажиллагаанд шаардлагатай эрчим хүчийг дотоод, гадаад эх үүсвэрээс хангах, нөөц эх үүсвэр бий болгох боломжийг судалж, дүгнэлт гаргах зорилгоор УУХҮС болон ЭХС-ын хамтарсан А/58/36 дугаар тушаалаар ажлын хэсэг 2018.03.12-ны өдөр байгуулагдсан. Үүний дагуу ажлын хэсгийн гишүүд Дорнод, Сүхбаатар аймгуудад байрлах Шинь Шинь ХХК, Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК, Петрочайна Дачин Тамсаг ХХК, Цайрт минерал ХХК болон Эм эл цахиурт овоо ХХК-иудад 2018.04.02-08-ны өдрүүдэд ажиллаж, тус ажлын үр дүнд гарсан дүгнэлтийг ажлын хэсгийн 2018.05.28-ны өдрийн хуралд танилцуулж, ажлын хэсгийн гишүүдээр хэлэлцүүлэн дүгнэлтийг гаргуулав. Үүний дагуу БНХАУ-аас Тамсаг XXI талбай хүртэл 18 км цахилгаан дамжуулах шугам татах нь зүйтэй гэсэн дүгнэлт гаргасан. Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг УУХҮЯ-ны Удирдлагын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, 2018.10.18-ны өдөр 07 дугаар тэмдэглэл гарсан. Уг дүгнэлтийн дагуу Чойбалсангийн ДЦС-аас Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбай руу цахилгаан нийлүүлж буй трансформатораас хамаарах цахилгаан эрчим хүчний хязгаарлалтын асуудлыг шийдвэрлэх зорилгоор 25 МВА-ын трансформаторын барилга угсралтын ажлыг 2018 оны 9 дүгээр сард эхлүүлж, 2019 оны 3 дугаар сард бүрэн ашиглалтанд оруулсан ба цахилгаан эрчим хүч дамжуулах хүчин чадал нь 15.5 МВт-аас 24.5 МВт болж нэмэгдсэн. Газрын тосны олборлолтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд гэрээлэгч компаниудын 2019 оны ажлын төлөвлөгөө, төсөвт ашиглалтын 3 талбайд нийтдээ шинээр 63 цооног өрөмдөн ашиглалтанд оруулахаар баталсан ба нийт хөрөнгө оруулалтын хэмжээ нь 249.6 сая ам.доллар байна. Мөн 2019 онд олборлолтыг нэмэгдүүлэх зорилгоор хийгдэх цооногийн өрөмдлөг, перфораци, шингэн хагалбар, полимер шахах, цооногийн засвар үйлчилгээ зэрэг технологийн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх | | | | зорилтот түвшинд хүрэх | ажлуудыг эрт эхлүүлэх зорилгоор гадаадаас авах ажиллах хүчний Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг ЗГ-ын 2019.03.27-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 118 дугаар тогтоолоор “Петрочайна дачин тамсаг” ХХК-ийн 696 ажилтан, Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн 92 ажилтанд Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг тус тус олгосон. БХГ-нүүдийг шинэчлэх Ажлын хэсгийг УУХҮСайдын 2018.01.17-ны А/12 тоот тушаалаар шинэчлэн байгуулж хайгуулын шатны БХГ-үүдийг шинэчлэн байгуулж БХГ-ний хэрэгжилтийн талаар ЗГ-ын 2018.05.02-ны өдрийн хуралдаанаар танилцуулсан ба 20 дугаар тэмдэглэлийг гаргуулсан.<br>Газрын тостой холбогдсон үйл ажиллагааны талаарх танилцуулгыг ЗГ-ын хуралдаанд танилцуулахаар холбогдох ЗГ-ын тэмдэглэлийн төсөл, танилцуулга бэлтгэн ЗГХЭГ-т 2019.11.22-ны өдрийн 01/3265 дугаар албан бичгээр хүргүүлэв. Энэхүү асуудлыг ЗГ-ын 2019.12.11-ны өдрийн хуралдаанаар танилцуулав.<br>-Тариач-XV талбайн БХГ-г шүүхийн шийдвэрээр сэргээх асуудлыг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ЗГ-ын тогтоолын төсөл, танилцуулга бэлтгэн 2019.10.10-ны өдрийн 01/2855 албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлэв. Энэхүү асуудлыг Засгийн газрын 2019.12.11-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, дэмжигдсэн ЗГ-ын тогтоол гаргуулсан.<br>-Магнай Трейд ХХК-ийн газрын тосны хайгуулын Баянтүмэн XVII талбайд байгуулсан БХГ-ний эрх, үүргийг “Түмэн Ойл” ХХК-д шилжүүлэх тухай ЗГ-ын тогтоолын төсөл, танилцуулга бэлтгэн ЗГХЭГ-т 2019.11.22-ны өдрийн 01/3267 дугаар албан бичгээр хүргүүлэв. Уг асуудлыг ЗГ-ын 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж Магнай Трейд ХХК-ийн газрын тосны хайгуулын Баянтүмэн XVII талбайд байгуулсан БХГ-ний эрх, үүргийг “Түмэн Ойл” ХХК-д бүхэлд нь шилжүүлэх тухай ЗГ-ын 452 дугаар тогтоол гарсан. 2020 оны газрын тосны олборлолт ашиглалтын хэмжээ нь Олон улсад тархаад байгаа цар тахал болох Ковид-19-тэй холбоотойгоор гадаад ажиллах хүч орж иржжгүйгээс шалтгаалан газрын тосны олборлолтын хэмжээ буураад байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 34 | 5. Газрын тосны ордын дэд бүтэц, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлэх | 2016 - 2020 | УУХҮЯ /ХҮГТБХЗГ/ | | Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 900,000.0 Тухайн жилийн зорилтот түвшинд хүрэх | Тосон-Уул XIX талбайгаас Баянхошууны хилийн боомт хүртэлх 210.7 км хатуу хучилттай авто замын 1, 2 болон 4 дүгээр хэсгүүд ашиглалтад орсон. Үлдсэн 3 дугаар хэсгийн нийт урт 52.6 км бөгөөд тус хэсгийн авто замын барилгын ажлын гүйцэтгэгчээр “Арж капитал” ХХК ажилласан. Авто замын барилгын ажил 2018.04.20-ны өдрөөс эхэлж, 2018.11 дүгээр сард 52.6 км авто замын асфальт бетонон хучилтын ажил дууссан. ЗТХЯ-ны ТНБД-ын 2018.11.13-ны өдрийн 375 дугаар тушаалаар тус авто замыг байнгын ашиглалтад авах ажлын хэсэг байгуулагдан 2018.11.22-ноос 23-ны өдрүүдэд ажиллаж, авто замыг ашиглалтад хүлээн авсан.<br>Тамсаг XXI талбайгаас дээрх чиглэлийн авто замд нийлэх Өмнөд Буйрын 58.5 км хатуу хучилттай авто замыг барих ажлыг 2019 оны ажлын төлөвлөгөө, төсвөөр батлуулсан ба 2018.10.23-ны өдөр “Петрочайна дачин тамсаг” ХХК нь тус замыг барьж байгуулах “Их Монгол барилга” ХХК-тай гэрээ байгуулсан. 2018 онд “Их монгол барилга” ХХК нь автозам барих нарийвчилсан төлөвлөгөө гаргаж, орон нутаг, Зам тээврийн хөгжлийн яамнаас холбогдох зөвшөөрлүүдийг авч, карьерийн шинжилгээ хийлгэсэн бөгөөд Тамсаг XXI талбайд автозамын ангийн кэмпээ байрлуулж, 20 км-т трасс татсан ба өвөл эхлэхэд ажлаа зогсоосон. 2019.03.20-ны өдрөөс автозамын ажлыг эхлүүлсэн. 2019.05.15-ны өдрийн байдлаар хөрс хуулалт 16,6 км-т, ул хөрс нягтруулалт 13,4 км-т, далангийн I үеийн дүүргэлт 11,5 км-т, I үеийн тэгшилгээ, нягтруулалт 10,2км-т, далангийн II үеийн дүүргэлт 640 метрт, трассын чиг сэргээлт 29 км-т хийгдсэн байна. Түүнчлэн ул хөрсний цогц шинжилгээ, I шороон ордын дээжийн давтан шинжилгээ, далангийн I үеийн цогц шинжилгээг хийж гүйцэтгэсэн ба өдөр бүр ул хөрс болон далангийн I үеийн талбайн нягтыг шалгах ажлыг тус тус хийж байна.<br>Тамсаг XXI талбайгаас Баянхошуу чиглэлийн хатуу хучилттай автозамтай холбох 68 км автозамын барилгын ажлыг эрчимжүүлэхээр Дорнод аймгийн Засаг даргын тамгын газар, Ашигт малтмал, газрын тосны газар, “Петрочайна Дачин Тамсаг” ХХК нар гурвалсан гэрээ байгуулан дээрх автозамын болон орд ашиглалтын дэд бүтэц, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын талаар хамтран ажиллаж байна. Замын суурь ажил хийгдэж байна. Автозамыг 2020 онд ашиглалтад хүлээлгэн өгөхөөр ажлыг эрчимжүүлэн ажиллаж байна. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 35 | 6. Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх хууль, журмыг чанд мөрдүүлж, ил тод хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх | 2016 - 2020 | УУХҮЯ /ХҮГТБХЗГ/ | | Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 2,000.0 Тухайн жилд хийхээр төлөвлөсөн байгаль орчин хамгаалах ажлыг хийх, хууль, журмыг мөрдүүлж хэвшүүлэх | БХГ-т талбайн хайгуул, ашиглалтын ажлын жилийн төлөвлөгөө, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын төлөвлөгөө, төсвийг тогтмол суулган баталж байгаа бөгөөд гэрээлэгчид байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх хууль, журмын дагуу байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх менежментийн төлөвлөгөө, хэрэгжилтийн тайланг БОАЖЯ-нд тогтмол хүргүүлэн дүгнэлт гаргуулан ажиллаж байна.<br>-"Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын үр дүнг хүлээн авах" журмыг УУХҮ-ийн сайд болон БОАЖ-ийн сайд нарын 2018.02.22-ны өдрийн А/50, А/31 тоот хамтарсан тушаалаар батлуулсан ба ХЗДХЯ-ны дэргэдэх Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2018.03.06-ны өдрийн 3870 дугаарт бүртгүүлсэн. Журмын хэрэгжилтийг хангуулан, холбогдох байгууллагуудтай хамтран хяналт тавьж ажиллах тухай 03/655 албан тоот бичгийг 2018.03.12-ны өдөр АМГТГ-т хүргүүлсэн.<br>-Дорнод аймгийн нутаг дэвсгэрт уул уурхай, газрын тосны үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, химийн хортой болон аюултай бодисыг ашиглах үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө болон дүгнэлт өгөх, шаардлагатай арга хэмжээ авах, санал боловсруулах үүрэг бүхий БОЯЖСайдын ахалсан ажлын хэсэг "Петрочайна дачин тамсаг" ХХК-ийн Газрын тосны XIX, XXI талбайн үйл ажиллагаа, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлттэй холбоотой хууль, журмын хэрэгжилт, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлттэй газар дээр танилцан, дээрх компаниудын удирдлага, төлөөлөлтэй уулзалт хийж, холбогдох асуудлуудаар санал солилцон, заавар зөвлөгөө, үүрэг чиглэл өгч, зарим тулгамдсан асуудлуудыг газар дээр шийдвэрлэж ажилласан.<br>Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагааны үеийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх тухай хууль журмын хэрэгжилтэд хяналт тавьж, заавар, зөвлөгөө өгч, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.<br>Үүнд:<br>- "Петро Матад" ХХК-ийн хайгуулын талбайд орхигдож тоногдсон өрмийн тоног төхөөрөмж, химийн бодисын асуудлыг АМГТГ-ын даргын тушаалаар батлагдсан ажлын хэсэг 2 удаа газар дээр нь очиж ажиллан холбогдох дүгнэлтийг гаргаад байна.<br>АМГТГ-ын 2019.06.25-ны өдрийн А/121 дугаар тушаалаар байгуулагдсан "Газрын тосны хайгуул, ашиглалт, олборлолтын үйл ажиллагааны үед ялгарч буй шингэн хаягдлыг цуглуулах, хадгалах, тээвэрлэх, цэвэршүүлэх, дахин боловсруулах, устгахтай холбоотой харилцааг зохицуулах Үндэсний стандартын төсөл боловсруулах" ажлын хэсгээс ирүүлсэн стандартын төсөлд холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудаас санал авч, мөн УУХҮСайдын зөвлөлийн 2019.08.29-ний өдрийн ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэн холбогдох шийдвэрийг гаргуулж, уг стандартын төслийг Газрын тос, байгалийн хийн техникийн хорооны хурлаар хэлэлцүүлэхээр 2019.09.12-ны өдрийн 03/2593 дугаар албан бичгээр Стандарт, хэмжил зүйн газарт хүргүүлсэн ба тус хорооны 2019.10.24-ний ээлжит хурлаар хэлэлцүүлэн дэмжигдээд байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 36 | 7. Газрын тосны борлуулалттай холбогдсон гэрээ, хэлцлүүдийг хийж, үнэ болон худалдааны таатай нөхцөлийг бүрдүүлэх | 2016 - 2020 | УУХҮЯ /ХҮГТБХЗГ/ | | Дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэтэй уялдуулан газрын тосны борлуулалттай холбогдсон гэрээ, хэлэлцээрүүдэд оролцож, үнэ болон худалдааны нөхцөлийг сайжруулах | 2018 онд түүхий тос борлуулах гэрээ хэлэлцээрүүд хийгдээгүй ба Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн хувьд 2016 онд байгуулсан гэрээ, Доншен Газрын тос (Монгол) ХХК-ийн хувьд 2017 онд байгуулсан гэрээг тус тус сунгасан. Үүний шалтгааан нь борлуулах тосны үнийг тооцоолох аргачлал, хэмжих арга, хэмжилтийн цэг нь өөрчлөгдөөгүйтэй холбоотой. Газрын тосны хайгуулын Галба-XI талбайд бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан “Зон Хэн Юу Тиан” ХХК-ийн туршилтын журмаар олборлосон 500 тн газрын тосыг БНХАУ-ын Шандунь мужын “Чин Юань групп” компанид худалдах гэрээний хэлэлцээрийг 2018 оны 5 дугаар сарын 29-өөс 6 дугаар сарын 3”ны хооронд БНХАУ-ын Шандунь мужын Зибо хотод хийж, түүхий тосыг туршилтын журмаар худалдаалахаар болсон. Доншен газрын тос /Монгол/ ХХК болон UNIPEC компани хоорондын түүхий тосны худалдааны гэрээний үнэ, борлуулалт, тээвэрлэлтийн өртөгийн асуудлаарх хэлэлцээрийг 2016 оны 01 дүгээр сард зохион байгуулж, гэрээг сунгасан. Петрочайна Дачин Тамсаг ХХК нь газрын тосны борлуулалттай холбогдсон гэрээ, хэлцлүүдийг хийж, үнэ болон худалдааны нөхцөлийг өмнөх жилийн нөхцөл байдалтай уялдуулан сунгасан. Тосны борлуулттай холбогдсон хэлэлцээрт, олборлосон түүхий тосны борлуулалттай холбоотой асуудлаар гэрээлэгч нь гэрээний төслийг АМГТГ-т урьдчилан танилцуулсны үндсэн дээр гэрээг эцэслэн байгуулах, түүхий тос борлуулах асуудлаар хэлэлцээ хийхдээ өмнө нь байгуулсан гэрээний нөхцөлийг бууруулахгүй, талуудад ашигтай байх нөхцөлөөр хэлэлцээ хийх,тосны борлуулалтын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, шинээр байгуулах тохиолдолд АМГТГ-т урьдчилан мэдэгдэж, зөвшөөрөл авах, түүхий тосонд шинжилгээ хийлгэж, хүнцэл болон мөнгөн усны агууламжийг тодорхойлох зэрэг нөхцлүүдийг тусгасан.<br>Газрын тосны борлуулалттай холбогдсон түүхий тосны худалдааны гэрээний хугацаа дуусаагүй тул 2019 онд тос худалдаалах гэрээний хугацаа сунгагдсан болно. Шинээр хэлэлцээр хийгдээгүй. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 37 | | 8. Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу явагдаж буй газрын тосны хайгуулын ажлыг эрчимжүүлж, шинээр газрын тосны орд | 2016 - 2020 | УУХҮЯ /ХҮГТБХЗГ/ | | Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 75,000.0 Газрын тосны хайгуул, үнэлгээний ажил эрчимжиж, тухайн жилийн | БХГ-нүүдийг 2015 оны ЗГ-ын 104 дүгээр тогтоолоор батлагдсан загварт нийцүүлж шинэчлэх ажлын хүрээнд газрын тосны хайгуулын Богд IV, Онги V талбайд БХГ байгуулсан “Капкорп Монголиа” ХХК-ийн, газрын тосны хайгуулын Матад XX талбайд БХГ байгуулсан “Петро Матад” ХХК-ийн, газрын тосны хайгуулын Баянтүмэн XVII талбайд БХГ байгуулсан “Магнай трейд” ХХК-ийн гэрээг тус тус шинэчлэн байгуулсан. Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа эрхэлж буй бүх ААН-үүдийн БХГ-ний хэрэгжилтийн талаар ЗГ-ын 2018.05.02-ны, 2018.10.03-ны өдрийн хуралдаанаар тус тус танилцуулан 41 дүгээр тэмдэглэлийг гаргуулсан. Газрын тосны хайгуулын Баянтүмэн XVII талбайд БХГ байгуулсан “Магнай трейд” ХХК-ийн хайгуулын өрөмдлөгийн үйл ажиллагааг орон нутгаас зогсоосонтой холбоотой асуудлаар 2018.10.26-наас 28-ны хооронд Дорнод аймагт томилолтоор ажиллан, аймаг, орон нутгийн удирдлагуудтай уулзалт хийж, холбогдох мэдээлэл танилцуулгыг хийсэн. Уулзалт, хэлэлцээрүүдийн үр дүнд тухайн асуудлыг Дорнод аймгийн Чойбалсан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018.11.09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж, шийдвэрлэхээр тохиролцсон. 2019.06.07-оос 10-ны өдрүүдэд Дорнод аймаг, Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрт газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулж буй Магнай трейд ХХК, Петро Матад ХХК болон Макс Ойл ХХК-уудын төлөөлөл, орон нутгийн засаг захиргааны байгууллагууд, сумдын удирлагуудтай хамтарсан уулзалтыг зохион байгуулж газрын тосны хайгуулын өнөөгийн байдал, тулгамдсан асуудлуудаар хэлэлцүүлэг хийж ажилласан.<br>1. Газрын тосны хайгуулын ажлыг эрчимжүүлэх талаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>УУХҮС болон БОАЖС-ын 2019 оны А/15, 2019 оны А/20 дугаар хамтарсан тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн нэгдсэн дүгнэлтийг гаргаж Газрын тосны нэр бүхий 5 талбайг цуцлах асуудлыг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ЗГ-ын тогтоолын төсөл, танилцуулга бэлтгэн ЗГХЭГ-т 2019.11.22-ны өдрийн 01/3266 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>Газрын тосны хайгуулын ажлыг эрчимжүүлэх талаар Газрын тостой холбогдсон үйл ажиллагааны талаарх танилцуулгыг ЗГ-ын хуралдаанд танилцуулахаар холбогдох ЗГ-ын тэмдэглэлийн төсөл, танилцуулга бэлтгэн ЗГХЭГ-т 2019.11.22-ны өдрийн 01/3265 дугаар албан бичгээр хүргүүлсэн ЗГ-ын 2019.12.11-ний өдрийн хуралдаанаас тэмдэглэл гаргуулсан.<br>2. Газрын тосны хайгуулын Богд IV, Онги V, Т-1 талбайнуудад нүүрсний давхаргын метан хийн хайгуул хийх талаар Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах асуудлыг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхтэй холбогдуулан ЗГ-ын тогтоолын төсөл, танилцуулга, БХГ-ний төслүүдэд яамдаас санал авахаар УУХҮС-ын 2019.09.02-ний өдрийн 01/2477 тоот албан бичгийг яамдад хүргүүлж, ирүүлсэн саналыг нэгтгэн, ЗГ-ын тогтоолын төсөл, танилцуулгыг бэлтгэн ЗГХЭГ-т 2019.11.04-ний өдөр хүргүүлээд байна. 2020 оны 2 дугаар сарын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн гэрээ байгуулах эрх олгох тухай тогтоолыг гаргуулсан болно.<br>- Тариач XV талбайн БХГ-г шүүхийн шийдвэрээр сэргээх асуудлыг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ЗГ-ын тогтоолын төсөл, танилцуулга бэлтгэн 2019.10.10-ны өдрийн 01/2855 албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн ба ЗГ-ын 2019.12.11-ний өдрийн хуралдаанаас тогтоол гаргуулсан.<br>- Магнай Трейд ХХК-ийн газрын тосны хайгуулын Баянтүмэн XVII талбайд байгуулсан БХГ-ний эрх, үүргийг “Түмэн Ойл” ХХК-д шилжүүлэх тухай | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | илрүүлэх | | | | батлагдсан төлөвлөгөөт ажлыг хийж гүйцэтгэх | ЗГ-ын тогтоолын төсөл, танилцуулга бэлтгэн ЗГХЭГ-т 2019.11.22-ны өдрийн 01/3267 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>Газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-ийн 705 гадаад ажилтны Монгол Улсад хөдөлмөр эрхлэх асуудлыг НХХЯаманд уламжлан шийдвэрлүүлсэн.<br>- Газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй "Доншен газрын тос Монгол" ХХК-ийн 92 гадаад ажилтны Монгол Улсад хөдөлмөр эрхлэх асуудлыг НХХЯаманд уламжлан шийдвэрлүүлсэн Газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулж буй "Петро Матад" ХХК-ийн 130, "Смарт ойл Монголиа" ХХК-ийн 27 гадаад ажилтны Монгол Улсад хөдөлмөр эрхлэх асуудлыг НХХЯам, болон Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газарт уламжлан ажиллах хүчний асуудлыг шийдвэрлүүлж дэмжлэг үзүүлэн ажилласан. - --Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Таван толгойн нүүрсний бүлэг орд дээр Нүүрсний давхаргын метан хийн чиглэлээр Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулахаар төсөл ирүүлсэн Эрдэнэс метан ХХК-ний гэрээний төсөлд холбогдох яамдуудаас санал авч ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн гэрээнд гарын үсэг зурах эрх олгуулсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 38 | 9. Газрын тос болон уламжлалт бус газрын тосны хуримтлал байж болох газарт эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлэх | 2016 - 2020 | УУХҮЯ /ХҮГТБХЗГ/ | | Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 5,000.0 Эрэл, хайгуул, үнэлгээний ажлыг эрчимжүүлж, тухайн жилийн батлагдсан төлөвлөгөөт ажлыг хийж гүйцэтгэх | “Жи Өү Эйч” ХХК нь Газрын тосны тухай хуулийн 16 дугаар зүйлийн дагуу 2016.01.15-нд Номгон-IX газрын тосны хайгуулын талбайд НДМ хийн эрлийн ажил хийж гүйцэтгэх гэрээг хуучин нэрээр ГТГ-тай байгуулсан. Эрлийн ажлын хүрээнд өмнөх хайгуул судалгааны материалыг нэгтгэх, тойм нөөцийн үнэлгээ, хайгуулын ажлын хөтөлбөр боловсруулах ажлуудыг гүйцэтгэж, Газрын тосны тухай хуулийн 17.1-р заалтын дагуу 2016.07.21-ний өдөр дүгнэлт гаргуулсан байна. Газрын тосны тухай хуулийн 17.2-р заалтын дагуу “Номгон-IX” талбайд байгуулах нүүрсний давхаргын метан хийн 17.4-р заалтын дагуу АМГТГ-тай БХГ-ний хэлэлцээрийг хийж гүйцэтгэн 2017.05.03-ны өдөр хэлэлцэн тохирсон БХГ-ний төслийг УУХҮЯ-нд ирүүлсэн. Гэрээний төсөлд 2017 оны 8 дугаар сар, 2018 оны 2 дугаар сард яамдуудаас санал авч нэгтгэн ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>-Газрын тосны хайгуулын Номгон-9 дүгээр талбайд нүүрсний давхаргын метан хийн чиглэлээр Австрали Улсын хөрөнгө оруулалттай “Жи Өү Эйч” ХХК-тай БХГ байгуулах эрхийг АМГТГ-ын дарга Х.Хэрлэнд олгох тухай ЗГ-ын 2018.08.22-ны өдрийн 265 тоот тогтоолыг гаргуулсан. Тус гэрээг 2018.09.18-ны өдөр байгуулсан.<br>“Говийн гарц” ХХК хуучин нэрээр ГТГ-тай 2014 онд эрлийн гэрээ байгуулж, эрлийн ажлын тайлангаа 2017 оны 2 сард АМГТГ-т хүлээлгэн өгсөн бөгөөд 2017.11.01-ний өдөр АМГТГ-ийн “Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын техникийн зөвлөл”-өөр уг тайланг хэлэлцэн хүлээн авсан. “Говийн гарц” ХХК нь газрын тосны тухай хуулийн дагуу эрлийн гэрээний хүрээнд хийгдсэн ажлын үр дүнд газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулахаар БХГ байгуулах хүсэлтээ 2018.01.03-ны өдөр АМГТГ-т ирүүлсэн. Уг төслийг судлан үзээд бүх яамдаас санал авч нэгтгэж байна.<br>“Говийн гарц” ХХК хуучин нэрээр ГТГ-тай 2014 онд эрлийн гэрээ байгуулж, эрлийн ажлын тайлангаа 2017 оны 2 сард АМГТГ-т хүлээлгэн өгсөн бөгөөд 2017.11.01-ний өдөр АМГТГ-ийн “Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын техникийн зөвлөл”-өөр уг тайланг хэлэлцэн хүлээн авсан. “Говийн гарц” ХХК нь газрын тосны тухай хуулийн дагуу эрлийн гэрээний хүрээнд хийгдсэн ажлын үр дүнд газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулахаар БХГ байгуулах хүсэлтээ 2018.01.03-ны өдөр АМГТГ-т ирүүлсэн. Уг төслийг судлан үзээд бүх яамдаас санал авч нэгтгэж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болгоод байна.<br>Газрын тосны хайгуулын Богд IV, Онги V, Т-1 талбайнуудад нүүрсний давхаргын метан хийн хайгуул хийх талаар Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах асуудлыг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхтэй холбогдуулан ЗГ-ын тогтоолын төсөл, танилцуулга, Бүтээгдэхүүн хуваах гэрээний төслүүдэд яамдаас санал авахаар УУХҮСайдын 2019.09.02-ний өдрийн 01/2477 тоот албан бичгийг яамдад хүргүүлж, ирүүлсэн саналыг нэгтгэн, ЗГ-ын тогтоолын төсөл, танилцуулгыг бэлтгэн ЗГХЭГ-т 2019.11.04-ний өдөр хүргүүлсэн.<br>“Капкорп Монголиа” ХХК-ийн Богд IV, Онги V талбайд явуулж буй уламжлалт газрын тосны хайгуулын үйл ажиллагааг 2 жилээр сунгаж, УУХҮС-ын 2019.10.02-ны өдрийн А/192 дугаар тушаалаар 381 тоот тусгай зөвшөөрлийн гэрчилгээ олгов.<br>Газрын тосны хайгуулын Сулинхээр XXIIII талбайд БХГ байгуулсан “Шунхлай энержи” ХХК-ийн хайгуулын тусгай зөвшөөрлийг 2 жилээр сунгах УУХҮС-ын тушаалын төслийг боловсруулан тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан. -Газрын тосны хайгуулын Галба-11 талбайд газрын тосны | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 39 | 10. Хүлэмжийн хийг бууруулах чиглэлээр газрын тосны олборлолтоос гарч байгаа газрын тосны уусан хийг ашиглах чиглэлээр судалгаа хийх, ашиглах | 2016 - 2018 | УУХҮЯ /ХҮГТБХЗГ/ | | Гадаад эх үүсвэр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 100.0 Олон улсын туршлага, судалгааны үр дүнг үндэслэн боломжит хувилбарыг гаргах, хэрэгжүүлж эхлэх | "Дашваанжил" ХХК-иас тавьсан хүсэлтийн дагуу 2018 оны 2 дугаар сард тус компанийн төлөөлөлтэй уулзалт хийж, Тосон-Уулын ордоос олборлож буй шингэнээс ялган авч буй уусан хийг Япон улсад шинжлүүлэх талаар хэлэлцэн шаардлагатай мэдээ, материалыг нэгтгэн хүргүүлсэн ба олборлолтын талбай дээрээс уусан хийн дээж авах ажлыг зохион байгуулсан.<br>-БХГ-т Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайн газрын тосны орд газраас олборлосон шингэнээс ялган авсан уусан хийн хэмжээ, зарцуулалт дараах байдалтай байна. Үүнд:<br>-БХГ-т Тосон-Уул XIX талбайгаас нийт 10,666,957 м3 хийг ялгасанаас, 6,432,365 м3 хийг халаах зууханд, 508,428м3 хийг цахилгаан генераторт тус тус ашиглаж, илүүдэл буюу 3,726,164 м3 хийг бамбардсан байна. Та-1 олборлолтын нэгдсэн байгууламжийн өдөр тутмын мэдээнээс харахад хүйтний улиралд хоногт дунджаар 1800м3, дулааны улиралд 1100м3 хийг цахилгаан генераторт ашигласан.<br>-БХГ-т Тамсаг XXI талбайгаас нийт 8,417,740 м3 хийг ялгасанаас, 6,633,832 м3 хийг халаах зууханд, 603,523м3 хийг цахилгаан генераторт тус тус ашиглаж, илүүдэл буюу 1,180,385 м3 хийг бамбардсан. Та-2 олборлолтын нэгдсэн байгууламжийн өдөр тутмын мэдээнээс үзэхэд хүйтний улиралд хоногт дунджаар 2500м3, дулааны улиралд хоногт дунджаар 1450м3 хийг цахилгаан генераторт ашигласан байна.<br>-Тосон-Уул XIX талбайн хувьд 500кВт-ын 2 хийн генератортой бөгөөд үүний нэгийг тогтмол ажиллуулдаг, Тамсаг XXI талбайн хувьд 600 кВт-ын 4 хийн генератортой бөгөөд үүнээс 1-ээс 2-ыг тогтмол ажиллуулдаг байна. Хийн генераторын хүчин чадал болон тоо хэмжээг нэмэгдүүлснээр үйлдвэрлэх эрчим хүчний хэмжээг нэмэгдүүлэх бөгөөд шатааж буй (бамбардаж буй) хийг бүрэн ашигласан тохиолдолд 1.5-3 МВт орчим эрчим хүчийг гарган авах боломжтой гэж үзэж Тосон-Уул XIX талбайд шинээр 2 хийн үүсгүүр тавих асуудлыг тавьж, санал дүгнэлт гарган, ажлын төлөвлөгөө, төсөвт тусган ашиглалтанд оруулах талаар арга хэмжээ авч ажилласан. Одоогоор шинэ 2 хийн үүсгүүр нь тогтмол ажиллаж байна. Өвлийн улиралд хийн зарим хэсгийг нэгдсэн байгууламжийн халаалтад ашиглаж байна. Олборлосон шингэнээс ялган авсан уусан хийг дулааны улиралд орд ашиглалтаас хамааран 20 хүртэл хувийг бамбардаж шатааж шаардлага гарч байгаа ба өвлийн улиралд цахилгаан эрчим хүч гаргах, халаах зуух ажиллуулах зэрэг үйл ажиллагаанд бүрэн ашиглаж байна.<br>Газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-ийн ашиглалтын үйл ажиллагааны үед ялгарч буй газрын тосонд уусан хийг ашиглах талаарх асуудлыг тус компанид тавьж ирсэн бөгөөд өнөөгийн байдлаар уг хийг дотоод дулааны болон халаалтын зориулалтаар бүрэн ашиглаж байна. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 40 | | 11. Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй талбайд ой хээрийн түймэр гарах, тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор зурвас бүсийг байгуулах | 2016 - 2020 | УУХҮЯ /ХҮГТБХЗГ/ | | Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 100.0 Зурвас байгуулах ажлыг тухайн жилийн төлөвлөгөө, төсөвт нь суулгуулах, хэрэгжүүлж хэвшүүлэх | Хаврын хуурайшилтын үе эхэлсэнтэй холбогдуулан галын аюулаас хамгаалах зурвас бүс байгуулах шаардлагыг гэрээлэгчид тавьж, Тамсаг XXI талбайн галын аюулгүйн зурвасыг үйлдвэрлэлийн бааз болон нэгдсэн байгууламжийг, мөн цооногуудыг тойруулан галын аюулгүйн бүс, Тосон-Уул XIX талбайн үйлдвэрлэлийн бааз, нэгдсэн байгууламж, цооногуудаас 20-50 метр зайтай, 5-8 метр өргөн, 3-5 метр гүнтэй галын аюулгүйн зурвасыг татаж дуусгасан. Мөн 2019 онд олборлолтын цооног орчимд гал түймрээс сэргийлэх зурвасыг хийлгүүлэхээр төсөв батлуулсан бөгөөд 2019.06.01-ний өдрийн байдлаар Петрочайна Дачин Тамсаг ХХК нь уг ажлыг гүйцэтгэх компанийг шалгаруулах шатанд явж байна.<br>Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй талбайд ой хээрийн түймэр гарах, тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор зурвас бүсийг татаж үйл ажиллагаандаа хэвшүүлсэн. | 100 |
| 41 | | 12. Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийг “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга”-д хамруулах | 2016 - 2020 | УУХҮЯ /ХҮГТБХЗГ/ | | Улсын төсөв 2.5 "Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга"-д хамруулан тайланг жил бүр авах | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны А/06 дугаар тушаалаар Эрдэс баялгийн гэрээний мэдээллийн цахим сангийн үр нөлөө тогтвортой ажиллагааг дэмжих хүрээнд Ашигт малтмал газрын тосны газар болон нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээнүүдийг ил тод болгох цахим санд байршуулах үүрэг бүхий ажлын хэсгийн байгуулсан. Ажлын хэсэг нийт 12 удаа хуралдаж эрдэс баялгийн салбарын 12 төрлийн 434 гэрээг цахим санд байршуулсан байна. Үүнээс 26 гэрээ нь газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ байна. Энэ ажлын хүрээнд аж ахуй нэгжүүдийн “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга”-д хамрагдсан талаар судалгаа хийсэн ба гэрээлэгч компаниудыг ил тод байдлын санаачилгад хамрагдах талаар зөвлөмж өгч ажилласан ба “Петрочайна Дачин Тамсаг” ХХК, "Петро Матад" ХХК, “Сентрал Азиан Петролеум Корпорэйшн Лимитед” ХХК-иуд уг санаачлагад хамрагдаад байна. Дээрх ажлын хэсэг нь 2019 оны 04 дүгээр сарын 21-ны өдөр гэрээний цахим сангийн нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулсан бөгөөд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны А/13 дугаар тушаалаар ажлын хэсгийг шинэчлэн байгуулж эрлийн гэрээ болон бичил уурай эрхлэгч нартай байгуулсан гэрээг цахим санд байршуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.<br>“Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга”-ын зарчмыг хэрэгжүүлж, ил тод байдлыг хангах ажлын хүрээнд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахаар Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан ААН-үүдийн гэрээний үндсэн нөхцөлийн талаарх мэдээллээс бусад мэдээллийг ил тод болгон “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга”-ын ажлын албаны болон гэрээ.мн сайтад байршуулсан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 42 | 2.64.“Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын 3.1.2-т заасан иргэд бичил уурхайн салбарт хууль ёсны бүтцээр хоршиж ажиллах чиглэлийг хэрэгжүүлэн холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно. | 2. Хууль бусаар ашигт малтмал олборлогчдыг нэгдсэн зохион байгуулалтад оруулах ажлыг зохион байгуулах | 2016 - 2020 | УУХҮЯ /ГУУБХЗГ/ | | Нэгдсэн зохион байгуулалтад оруулах судалгаа хийх | Бичил уурхайн холбогдох хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжилтийг хангах, хувиараа ашигт малтмал олборлох хууль бус үйл ажиллагааг бичил уурхайн зохион байгуулалтад оруулах, албажуулах, байгаль орчны хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор БОАЖЯ, ТЕГ, МХЕГ, ЦЕГ, АМГТГ-тай хамтран ажиллаж байна. Тус яамнаас Байгаль орчин, аялал жуулчлалын сайдаар ахлуулсан ажлын хэсэгт холбогдох төлөөллийг оролцуулж, 2019 оны 9 дүгээр сарын 17 болон 12 дугаар сарын 17-ны өдрүүдэд Сэлэнгэ аймгийн Ерөө, Хүдэр сум, Бугант тосгонд ажиллаж хяналт шалгалт хийсэн бөгөөд хууль бусаар алт олборлож байсан үйл ажиллагааг таслан зогоох арга хэмжээг авч зөрчил гаргасан 48 үйлдэлд хамаарах зарим иргэн, аж ахуйн нэгжийг цагдаагийн байгууллагад шилжүүлсэн.<br>Түүчлэн ажлын хэсгээс хууль бусаар алт олборлох үйл ажиллагааг таслан зогсоох, холбогдох арга хэмжээг газар дээр нь хэрэгжүүлэх зорилгоор Сэлэнгэ аймагт 10 ажлын хэсэг 1 сарын хугацаатай ажиллуулахаар төлөвлөж, холбогдох зардлыг Засгийн газрын хуралдаанд танилцуулж, 2019 оны 341 дүгээр тогтоолоор батлуулсан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 43 | 2.65.Уул уурхайн дэд бүтцийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлт боловсруулж, салбар хоорондын уялдааг сайжруулна. | 2. Уул уурхайн дэд бүтцийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд салбар хоорондын уялдаа холбоог хангах | 2016 - 2020 | УУХҮЯ /ГУУБХЗГ/ | | Дэд бүтцийн хөгжлийн төсөл хэрэгжүүлэх | ТНБД-ийн 2017.10.09-ний өдрийн А/134 дугаар тушаалаар "Уул уурхайн дэд бүтцийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлтийн баримт бичиг"-ийн төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн хүрээнд Сангийн яам, Эрчим хүчний яам, Зам, тээврийн хөгжлийн яам, холбогдох агентлагаас төлөөллийг оруулж, шаардлагатай мэдээллийг авч нэгтгэн, уул уурхайн дэд бүтцийн хөгжлийн хөтөлбөрийн төслийг боловсруулан салбар хоорондын уялдааг хангах чиг үүргийн дагуу Үндэсний хөгжлийн газарт 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 01/2687 тоот албан бичгээр хүргүүлсэн. Гэвч Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 42 дугаар тогтоолоор Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтууд (2015-2030), Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засгийг сэргээх хөтөлбөр, Хөгжлийн зам хөтөлбөртэй уялдсан Гурван тулгуурт хөгжлийн бодлогыг батлан гаргасан. Уг бодлогын баримт бичгийн 3 дугаар зүйлд Бодлогын зорилтыг хангах үйл ажиллагааг зааж өгсөн бөгөөд 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтад "уул уурхайн хөгжлийг дэмжих тээвэр, дэд бүтцийг барьж байгуулах" асуудлыг тусгасан. Мөн Монгол Улсын Их Хурлын 2018 оны 37 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Монгол Улсын Нийгэм, эдийн засгийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд эрчим хүч, зам тээврийн асуудлуудыг тус тус тусгасан бол, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 325 дугаар тогтоолоор Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны үндэсний хөтөлбөр (2018-2023)-ийг, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 321 дүгээр тогтоолоор Төрөөс автотээврийн салбарт баримтлах бодлого"-ыг тус тус баталсан.<br>Дээр дурдсан бодлогын баримт бичиг, үндэсний хөтөлбөрүүдэд уул уурхайг дагасан бүтээн байгуулалтуудын ажлуудын төлөвлөлтийг тусган баталсан болно. | 100 |
| 44 | 2.66.Уул уурхайн судалгааны нэгж байгуулж, эрдэс баялгийн салбарт хөрөнгө оруулалтын таатай орчинг бий болгоно. | 1. Уул уурхайн судалгааны нэгж байгуулах талаар санал боловсруулах | 2017 | УУХҮЯ /ГУУБХЗГ/ | | | Уул уурхайн бодлогын газраас "Уул уурхайн судалгааны нэгж байгуулах" талаар судалгааг хийж, яамны удирдлагад танилцуулсан. | 100 |
| 45 | | 2. Уул уурхайн судалгааны нэгж байгуулах саналыг холбогдох байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх | 2017 | УУХҮЯ /ГУУБХЗГ/ | | | УУХҮЯ-ны бүтцийн өөрчлөлтийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулж, Засгийн газрын 2018 оны 370 дугаар тогтоолоор батлуулсан. Уг тогтоолоор судалгааны нэгжийн үүргийг гүйцэтгэх Эдийн засаг, хөрөнгө оруулалт, судалгааны хэлтсийг байгуулан үйл ажиллагаа явуулж байна. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 46 | 2.67.Хоёрдогч ашигт малтмал ашиглах эрх зүйн орчинг бий болгож, уурхайн нөхөн сэргээлт, хаалтыг олон улсын жишигт хүргэнэ. | 2. Уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн журмыг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж мөрдүүлэх | 2017 - 2018 | УУХҮЯ /ГУУБХЗГ/ | | Журам батлагдан мөрдөгдөж эхлэх | Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журмын төсөл, нөлөөллийн шинжилгээний тайлан боловсруулж, батлуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018.04.24-ний өдрийн А/88 дугаар тушаалаар байгуулсан. Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журмын төслийг эцэслэн боловсруулж, УУХҮС, БОАЖС нарын 2019 оны А/181/А/458 дугаар тушаалаар батлуулж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2019.11.21-ний өдрийн 4530 дугаарт бүртгүүлсэн. | 100 |
| 47 | 2.68."Алт-2" хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг Монголбанктай хамтран шийдвэрлэнэ. | 1. "Алт-2" хөтөлбөрийн санхүүжилтийн тооцоог гаргах | 2017 | УУХҮЯ /ГУУБХЗГ/ | | | Нөөц нь тогтоогдсон алтны ордуудыг эргэлтэд оруулах санхүүжилтийн асуудлаар Сангийн яам, Монголбанкны холбогдох хүмүүс, алт олборлогч томоохон 25 аж ахуйн нэгжийн төлөөллийг оролцуулсан уулзалтыг УУХҮЯ-нд зохион байгуулсан. Санхүүжилт шаардлагатай алтны 130 төслийн мэдээллийг нэгтгэж Хөгжлийн банкинд хүргүүлсэн.<br>- Хөтөлбөрийн хүрээнд санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд Хөгжлийн банктай хамтран ажиллахаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны А/249 дугаар тушаалаар ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн хуралдаанаар УУХҮЯ-аас гаргасан санал, хүсэлтийн дагуу "Алт-2" үндэсний хөтөлбөрийн хүрээнд алт олборлогч аж ахуйн нэгжүүд санхүүжилт хүсэхэд тулгамдаж буй асуудлуудыг Хөгжлийн банканд танилцуулсан. Энэ ажлын үр дүнд Хөгжлийн банк нь алт олборлогч нарт олгох зээлэнд хүүгийн хөнгөлөлт үзүүлэх нөхцлийг зөвшөөрсөн. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 48 | | 2. Санхүүжилтийн тооцоог Монголбанкинд хүргүүлж шийдвэрлүүлэх | 2016 - 2017 | УУХҮЯ /ГУУБХЗГ/ | | | Алт хөтөлбөрийн хүрээнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх аж ахуйн нэгжүүдийн судалгаа, зээлийн хэмжээг тооцоолон 2017 онд Монголбанкинд хүргүүлсэн.<br>- ОУВС-тай байгуулсан гэрээ, хэлэлцээрийн үндсэнд Монголбанкнаас алтны санхүүжилтийн эх үүсвэрийг гаргах боломжгүй болсон. Санхүүжилтийн асуудлыг Сангийн яам болон Хөгжлийн банктай хамтран шийдвэрлэсэн. Үүний үр дүнд: 1. Монгол Улсын Сангийн яамнаас хувиарласан эх үүсвэрийн хэмжээ, хугацаанд нийцүүлэн алт олборлогч компаниудад эргэлтийн болон тоног төхөөрөмж худалдан авах зориулалтаар зээлийг олгох, 2. Хэрэв зээл олгосон компани нь олборлосон алтныхаа тодорхой хэсгийг Монгол банкинд тушааж, зээлийг хугацаанд нь эргүүлэн төлсөн тохиолдолд хүүгийн хөнгөлөлт үзүүлж, урамшуулах. Нэгдүгээр зорилтын хүрээнд: 2017 онд ирүүлсэн 27 хүсэлтээс 10 аж ахуйн нэгжид 35.4 тэрбум төгрөг, 2018 онд ирүүлсэн 7 хүсэлтээс 2 аж ахуйн нэгжид 21.6 тэрбум төгрөг, 2019 онд ирүүлсэн 6 хүсэлтээс 1 аж ахуйн нэгжид 16.0 тэрбум төгрөг, нийт гуван жилийн хугацаанд 13 аж ахуйн нэгжид 73.0 тэрбум төгрөгийн санхүүжилтыг олгосон байна. 2019 оны жилийн эцсийн байдлаар 9 аж ахуйн нэгжийн 54.7 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Хөтөлбөрийн үр дүнд 13 аж ахуйн нэгжийн 1478 ажлын байрыг хангаж, 2017 онд 159.1 кг, 2018 онд 649.3 кг, 2019 онд 175.3 кг буюу нийт 983.7 кг алт олборлон Монголбанканд тушааж, 4.6 тэрбум төгрөгийн татварыг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрт төвлөрүүлсэн байна. 2-р зорилтын хүрээнд: МУХБанкаас олгосон 13 зээлдэгч зээлийг хугацаандаа төлж, хүүний урамшуулалд хамрагдсан. Нийт олгосон 73.0 тэрбум төгрөгийн зээлийн багцаас 18.4 тэрбум төгрөгийн зээл төлөгдсөн байна. 2019 оны эцсийн байдлаар 9 зээлдэгчийн 54.7 тэрбум төгрөгийн зээлийн 54.4% буюу 2 зээлдэгч чанаргүй зээлийн ангилалд бүртгэгдэн, 14.7 тэрбум төгрөгийн эрсдлийн сан байгуулсан байна. Хөтөлбөрийн хүрээнд олгосон 13 төслөөс 2 төсөл хэвийн төлөгдөж, 8 төсөл чанаргүй болсон тул Зээлийн хяналтын тусгай активын хэлтэст шилжин 2 зээлийг бүрэн төлүүлэн, одоогоор 6 зээлийн 22.8 тэрбум төгрөгийн багцыг төлүүлэхээр ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 49 | 2.69.Алтны олборлолтыг нэмэгдүүлж, бичил уурхай эрхлэгчдийн олборлосон алтыг худалдан авах эрх зүйн орчинг бүрдүүлнэ. | 2. Хөтөлбөр батлагдсантай холбогдуулан холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах | 2017 - 2018 | УУХҮЯ /ГУУБХЗГ/ | | Хууль тогтоомжийн төслүүдийг боловсруулан, батлуулах | Алтны татварын эрх зүйн орчинг тогтвортой байлгах үүднээс Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, үзэл баримтлал, урьдчилсан тандан судалгааны хамтаар боловсруулж Засгийн газрын 2018 оны 10-р сарын 31-ний өдрийн 45 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдсэн. Хуулийн төслийг 2018 оны 12-р сарын 20-ны өдрийн УИХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр өргөн барьсан. УУХҮС-ын 2018 оны 2-р сарын 13-ны өдрийн А/28 дугаар тушаалаар "Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам"-ыг, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн "Дүрэм аргачлал батлах" тухай УУХҮС-ын 2018 оны 2-р сарын 26-ны А/46 дугаар тушаалаар дүрэмд холбогдох өөрчлөлт оруулж ордын нөөцийг бүртгэж эхэлсэн. “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”, “Алт-2” хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор төрийн өмчит “Эрдэнэс Монгол” компанийн 100%-ийн эзэмшлийн “Эрдэнэс алт ресурс” компанийг байгуулан үйл ажиллагааг дэмжин ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд алт олборлолтыг нэмэгдүүлэх зорилгоор санаачлан Монгол Улсын хэмжээнд "Эх орныхоо алтыг эрдэнэсийн сандаа" аяныг Монголбанктай хамтран 5 сарын хугацаанд амжилттай зохион байгуулж алт тушаалтын хэмжээг 1.9 тн-оор нэмэгдүүлсэн. Энэ ажлын хүрээнд Дархан-Уул, Баянхонгор аймагт алт худалдан авах, сорьц тогтоох нэг цэгийн төвийг 265 сая төгрөгийн өртөгтэйгээр байгуулагдаж орон нутагт алтыг худалдан авч эхэлсэн. Хөтөлбөрийн хүрээнд санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд Хөгжлийн банктай хамтран ажиллахаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны А/249 дугаар тушаалаар ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлуусан. Мөн Монголбанк түүнээс эрх олгосон арилжааны банканд тушаасан алтны ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээг 5 хувь байх зохицуулалтыг тусгасан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хурлын 2019 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцүүлж батлуулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 50 | 3. Алтны геологийн судалгаа, эрэл-үнэлгээ, хайгуулын ажлыг хэмжээг өсгөн нөөцийг тогтвортой нэмэгдүүлэх | 2017 - 2018 | УУХҮЯ /ГУУБХЗГ/ | Батлагдсан -1,291.3 Гүйцэтгэл – 293.7 Санхүүжилт – 293.7 | Улсын төсөв 1,000.0 Хэтийн төлвийн үнэлгээ хийх, алтны ордын баялаг, нөөцийн хэмжээг тогтоох | Монгол орны төв, зүүн бүсийн алтны нөөцийн хэтийн төлвийн үнэлгээ хийх геологийн судалгааны ажлын "ТЗМ-Алт-2017" төслийн төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын 2019 оны А/13 дугаар тушаалаар батлуулсан. Төслийн 2019 онд гүйцэтгэх хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлал, төсвийн тодотголыг ЭБМЗ-өөр 2019.02.21-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн УУХҮС-ын 5-р сарын 03-ны өдрийн А/84 дүгээр тушаалаар батлуулсан. Хээрийн судалгааны ажлыг 2017-2018 онд гүйцэтгэж дууссан бөгөөд 521,200.0 кв.км талбай буюу 33.3%-д тархсан алтны хүдэржилт бүхий талбай, дүүрэг, зангилаа, түүнд тогтоогдсон орд, илрэл, эрдэсжсэн цэг, сарнилын хүрээ бүхий хэсгүүдийг нарийвчилан судалсан. 2020 онд тухайн нутаг дэвсгэрийн 100%-ийг хамарсан хэсэгт тогтоогдсон талбайнуудад хийгдсэн өмнөх онуудын хээрийн судалгаа ажлын үр дүн, лабораторийн шинжилгээний хариуг боловсруулан хэтийн төлөвийг тогтоон, үр дүнгийн тайланг боловсруулан ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.<br>-2019 оноос хэрэгжүүлж эхэлсэн Монгол орны баруун, баруун өмнөд, хангайн бүсийн алтны хэтийн төлөвийн судалгааны ажил "БӨМ-Алт-2019"-ын 2020 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын 2019 оны А/254 дүгээр тушаалаар батлуулсан. Төслийн 2020 оны суурин болон хээрийн судалгааны ажлын хэмжээ, арга аргачлалыг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн УУХҮС-ын А/125 дугаар тушаалаар батлуулж судалгааны ажлыг эхлүүлээд байна.<br>-2020 оны эхний хагас жилд ЭБМЗ-ийн салбар зөвлөлийн хуралдаанаар алтны хайгуулын ажил гүйцэтгэсэн 18 үр дүнгийн тайланг хэлэлцэж үндсэн 4 ордын 28,600 кг, шороон 14 ордын 2,236 кг буюу нийт 30,836 кг алтны нөөцийг Улсын нөөцийн нэгдсэн бүртгэлд бүртгэсэн.<br>- Ашигт малтмалын тухай хуульд 2014 онд орсон нэмэлт, өөрчлөлтөөр Монгол банк, түүнээс эрх олгосон арилжааны банкинд тушаасан алтны нөөц ашигласны төлбөрийг 5 жилийн хугацаанд 2.5 хувь болгон өөрчилсний үр дүнд алтны үйлдвэрлэл, тушаалт нэмэгдэж, эдийн засгийн өсөлтөд бодитоор өөрчлөлт үзүүлсэн. Тухайлбал, Монгол банкинд тушаасан алтны хэмжээ 2014 онд 12.7 тонн, 2015 онд 15.1 тонн, 2016 онд 18.3 тонн, 2017 онд 20 тонн, 2018 онд 21.9 тонн, 2019 онд 15.2 тонн байгаа бол 2020 оны 5-р сарын байдлаар 8.5 тонн байна. | 100 |
| 51 | 4. Сорьцын хяналтын албаны чадавхийг бэхжүүлж, техник технологийг шинэчлэх | 2016 - 2017 | УУХҮЯ /ГУУБХЗГ/ | | Улсын төсөв 1,200.0 Хүчин чадлыг нэмэгдүүлж, техник технологийг шинэчлэх | Швейцарийн Хөгжлийн Агентлаг /ШХА/-ийн "Тогтвортой бичил уурхай" төслөөс 2016 онд 6 кг хүртэлх жинтэй алт хайлах зуух /1 ширхэг/, дагалдах тоног төхөөрөмжийн хамт 40,0 сая орчим төгрөгөөр Сорьцын хяналтын газарт худалдан авч өгсөн. 2019 онд Монгол банкны 180 сая төгрөгийн санхүүжилтээр Ховд хотод сорьцын лаборатори байгуулахаар ажиллаж байна. Мөн Улаанбаатар хотод алт хайлуулах зуух тавихаар Монгол банкаас шийдвэрлэсэн байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 52 | 5. Алтыг боловсруулж нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, алт цэвэршүүлэх үндэсний үйлдвэрийг байгуулах | 2017 | УУХҮЯ /ГУУБХЗГ/ | | Гадаад зээл 2,000.0 Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх | Улсын Их Хурлын Байнгын хорооны 2018.10.30-ны өдрийн “Чиглэл өгөх тухай” 32 дугаар тогтоолд “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.69 дэх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд 2019 онд багтаан дотооддоо алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлэхийг МУ-ын ЗГ /Ү.Хүрэлсүх/, Монголбанк /Н.Баяртсайхан/-нд чиглэл болгосон.<br>-Улсын Их Хурлын Байнгын хорооны 2018 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн “Чиглэл өгөх тухай” 32 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А-303 тогтоолоор Монгол Улсад алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлын цогц төлөвлөгөө боловсруулах, холбогдох тооцоо судалгаа хийж танилцуулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.<br>-ЗГ-ын 2019 оны 02 дугаар сарын хуралдаанаар алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах асуудлыг хэлэлцэж “Стратегийн ач холбогдолтой том төслийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” ЗГ-ын тэмдэглэл гарсан.<br>-Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2019.02.27-ны өдөр алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах асуудлаар “Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах тухай” зөвлөмж гарсан. Тус зөвлөмжийн хэрэгжилтийг хангах хүрээнд Тагнуулын ерөнхий газраас ЗГХЭГ-т алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах асуудлыг нууцад хамруулах асуудлаар ЗГ-ын тогтоолын төслийг боловсруулж, ЗГ-ын хуралдаанаар зохих журмын дагуу хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн.<br>-Алт цэвэршүүлэх үйлдвэрийн технологийн харьцуулсан судалгааг боловсруулж Казахстан Улсын “Данель М” ХХК-ийн эзэмшдэг Евро-Азийн патентын холбоогоор баталгаажсан “Үнэт металл цэвэршүүлэх инновацийн технологи” /Вакуум дистилляцийн арга/-ийг Монгол улсад шинээр баригдах алт цэвэршүүлэх үйлдвэрт ашиглахаар сонгож, тус компаниар алт цэвэршүүлэх үйлдвэрийн ТЭЗҮ-г Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэсэн. | 70 |
| 53 | 6. Ашиглалтад оруулахад бэлэн болсон алтны уурхай, баяжуулах үйлдвэрийг байнгын ашиглалтад оруулахад дэмжлэг үзүүлэх | 2016 - 2020 | УУХҮЯ /ГУУБХЗГ/ | | Алтны олборлолтын хэмжээ нэмэгдэх | Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.61.4, 2.69.6-д заасан “Эдийн засгийн үр ашигтай төслүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх” хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн А/16 дугаар тушаалаар Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг ашиглатад хүлээн авах журмыг баталж, 2020 онд үйл ажиллагаа эхлүүлэх бэлтгэл ажлаа хангасан 11 уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг ашиглалтад хүлээн авч 1500 орчим ажлын байрыг шинээр бий болгосон. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 54 | | 7. Бичил уурхай төвлөрсөн нутаг дэвсгэрт алтны худалдааны нэг цэгийн үйлчилгээ байгуулах талаар судалж хэрэгжүүлэх | 2016 - 2019 | УУХҮЯ /ГУУБХЗГ/ | | Холбогдох байгууллагад асуудлыг танилцуулж шийдвэрлүүлэх Үйлдвэрийн барилгын ажил явагдах Үйлдвэрийн барилгын ажил явагдах | Сайдын 2018.02.26-ны өдрийн А/47 дугаар тушаалаар байгуулагдсан "Алтны нийлүүлэлтийн сүлжээг боловсронгуй болгох" үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж алтны сорьц тогтоох, худалдан авах нэг цэгийн үйлчилгээний төвийн байршлыг хуралд оролцогчид Баянхонгор болон Дархан-Уул аймгууд байх нь зүйтэй гэж 100 хувийн саналаар баталсан. "Алт-2" хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор төрийн өмчит "Эрдэнэс Монгол" компанийн 100%-ийн эзэмшлийн "Эрдэнэс алт ресурс" компанийг байгуулан үйл ажиллагааг дэмжин ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд алт олборлолтыг нэмэгдүүлэх зорилгоор санаачлан Монгол Улсын хэмжээнд "Эх орныхоо алтыг эрдэнэсийн сандаа" аяныг Монголбанктай хамтран 5 сарын хугацаанд амжилттай зохион байгуулж алт тушаалтын хэмжээг 1.9 тн-оор нэмэгдүүлсэн. Энэ хүрээнд Дархан-Уул, Баянхонгор аймагт алт худалдан авах, сорьц тогтоох нэг цэгийн төвийг 265 сая төгрөгийн өртөгтэй байгуулан ажиллуулж байна. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 55 | 2.70.Газрын тосны олборлолтыг тогтвортой нэмэгдүүлэн, газрын тос боловсруулах үйлдвэр байгуулна. | 4. Барилгын ажлыг гүйцэтгэж, үйлдвэрийг хүлээн авч ашиглалтад оруулах | 2017 - 2020 | УУХҮЯ /ХҮГТБХЗГ/ | 173,100.00 | Гадаад зээл 800,000.0 Үйлдвэрийн барилгын ажил явагдах | Дорноговь аймгийн Алтанширээ суманд баригдах газрын тос боловсруулах үйлдвэрт шаардлагатай түүхий тосыг тээвэрлэх дэд бүтцийн оновчтой хувилбарыг тодорхойлох үүрэг бүхий ажлын хэсгийг МУ-ын Ерөнхий сайдын 2019.09.16-ны өдрийн 118 дугаар Захирамжаар байгуулсан. Уг ажлын хэсэг нь газрын тос боловсруулах үйлдвэрт шаардлагатай түүхий тосыг тээвэрлэх дэд бүтцийн оновчтой хувилбарыг тодорхойлох, үр ашгийн харьцуулсан судалгааг "Монголын логистикийн холбоо"-гоор гүйцэтгүүлэн тайланг Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж ЗГ-ын 01 дүгээр тэмдэглэлээр түүхий тосыг дамжуулах хоолойгоор тээвэрлэхээр шийдвэрлэсэн.<br>Мөн Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 11 дүгээр тэмдэглэлээр дамжуулах хоолой барих төслийг санхүүжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг дотоод, гадаадын зээл, тусламж, шаардлагатай бусад эх үүсвэрийн хүрээнд шийдвэрлүүлэх талаар судалж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Сангийн сайдад, төслийн санхүүжилтийг шийдвэрлэсний дараа бүтээн байгуулалтын ажлыг удирдан зохион байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад тус тус даалгасан.<br>Дээрх шийдвэрийн дагуу тус яамнаас дамжуулах хоолойн санхүүжилтийн талаар санал боловсруулж ЗГ-ын хуралдаан танилцуулж өгөх хүсэлтийг УУХҮ-ийн сайдын 2020.02.17-ны өдрийн 01/464 дугаар болон 2020.04.10-ны өдрийн 01/1002 дугаар албан бичгүүдээр Сангийн сайдад хандаад байна.<br>"Газрын тос боловсруулах үйлдвэр, үйлдвэрийн усны эх үүсвэр болон ус хангамжийн шугам хоолойн дагуу байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ" боловсруулах Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээг "Газар дэлхий" ХХК болон "Хатан далай" ХХК-иудтай байгуулж 2020 оны 3 дугаар сард БОАЖЯ-ны дэргэдэх Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэргэжлийн зөвлөлөөр тайланг хэлэлцүүлэн батлуулаад байна.<br>Төслийн менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу газрын тос боловсруулах үйлдвэрийн төлөвлөлт, инженерчлэл, зураг төсөл боловсруулах ажлыг гүйцэтгэж байгаа бөгөөд үйлдвэрийн технологийн бус барилга байгууламжийн барилга-угсралтын ажлын ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлаж БНЭУ-ын Жи Эм Си Прожектс Индиа компани шалгаран төслийн менежментийн зөвлөх компанитай ажил гүйцэтгэх гэрээ байгуулахаар хэлэлцээр хийж байна.<br>Мөн лицензгүй технологийн барилга байгууламжийн ерөнхий дизайн, зураг төслийн багцыг захиалагчийн инженерийн хамт тооцоолон хянаж, сайжруулж болох санал, зөвлөмжүүдийг төслийн менежментийн зөвлөх компанид хүргүүлээд байна.<br>Дорноговь аймгийн Сайншанд суманд байгуулж буй газрын тос боловсруулах үйлдвэрийн ажилчдын хотхоны бүтээн байгуулалтын ажил 2020 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар эхний ээлжийн 4 орон сууцны 5 давхар, офисс-үйлчилгээний барилгын 1 давхрын цутгалтын ажил тус тус хийгдсэн.<br>**Үйлдвэрийн дэд бүтцийн талаар:**<br>*Авто зам:* Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас газрын тос боловсруулах үйлдвэрийн авто зам, замын байгууламжийн барилгын ажлын явцад өгсөн үүрэг даалгаврын биелэлтэнд 2020 оны 5 | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дугаар сарын 19-ний өдөр хяналт шалгалт хийж, хэрэгжилттэй нь танилцаж, цаашид хийж гүйцэтгэх ажлын үүрэг даалгаварыг өгөн ажилласан.<br>*Төмөр зам:* Газрын тос боловсруулах үйлдвэрийг Сайншанд хоттой холбосон төмөр замын тээвэрлэлт, арчлалт, хамгаалалтын ажлыг “Монголиан транс ложистик” ХХК хийж гүйцэтгэж байна.<br>*Эрчим хүч:* Бор хөөврийн говийн усан хангамжийн эрчим хүчний ЦДАШ, дэд станц барих урьдчилсан тооцоог Монгол улсад хэрэглэгдэж байгаа үнийн жишгийг үндэслэн боловсруулаад байна.<br>Мөн үйлдвэрийн газрыг хашаажуулах болон талбайн газар шорооны ажлуудыг 2020 оны 04 дүгээр сараас гүйцэтгэж эхлээд байна.<br>Уг ажил 6 дугаар сарын байдлаар үйлдвэрийн талбайн тэгшилгээний ажил 20%-ийн гүйцэтгэлтэй, нийт 5000 м хамгаалалтын хашаа (1500 м төмөр бетон, 3500 м төмөр сараалж) барихаас 1500 м төмөр бетон хашааг талбайд зөөвөрлөөд байна.<br>Дээрх ажлын явцыг эрчимжүүлэхээр Барилга, хот байгуулалтын яам болон уг ажлын барилгын захиалагчийн хяналтыг гүйцэтгэж буй “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-тай хамтарсан ажлын хэсэг байгуулж ажлын гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 56 | 2.71.Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлыг дэмжиж ажиллана. | 3. Үйлдвэр байгуулж, ашиглалтад оруулах | 2017 - 2020 | УУХҮЯ /ХҮГТБХЗГ/ | | Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 862,400.0 Үйлдвэрийн барилгын ажил явагдах | 1. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих зорилгоор Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэрт орших 466 га газрыг үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэх зориулалтаар Засгийн газрын 2018.12.12-ны өдрийн "Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай" 378 дугаар тогтоол батлагдсан. Тус тогтоолын дагуу 2019.04.03-ны өдөр улсын тусгай хэрэгцээнд газрыг ашиглуулах тухай 2019/01 дугаар гэрээг байгуулаад байна.<br>Түүнчлэн тус үйлдвэрийг байгуулах тухай асуудлыг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр хэлэлцүүлж, зөвлөмж гарсан бөгөөд Засгийн газрын 2019.05.17-ны өдрийн "Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай" 196 дугаар тогтоолоор Засгийн газрын 2017.9.13-ны өдрийн 247 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт"-д хамруулж нэн чухал асуудлаар анхааран ажиллаж байна.<br>2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны төсвийн багцад Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулах зардлыг тусгуулж, УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны "Үнэлгээний хороо байгуулах тухай" А/113 дугаар тушаалаар Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн Техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах зөвлөхийг сонгон шалгаруулах үүрэг бүхий үнэлгээний хороо байгуулагдан ажилласан боловч ЗББҮ-ийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах зөвлөхийг сонгон шалгаруулахтай холбоотой үйл ажиллагаа нь Төрийн нууцад хамаарсан тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4-т заасны дагуу зохион байгуулахыг Тагнуулын Ерөнхий Газрын 2019.09.18-ны өдрийн 01/1281 дугаар албан бичгээр уламжилсан. Иймд тендерийн үйл ажиллагааг цаашид үргэлжлүүлэх боломжгүй болсон. Улмаар Төрийн нарийн бичгийн даргын 2019.11.28-ний өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" А/203 дугаар тушаалаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4-т заасныг үндэслэн Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсэг байгуулагдан 2019.12 дугаар сард гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулаад байна.<br>Төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулснаар төслийн хөрөнгө оруулагчыг сонгон шалгаруулж барилгийн ажлыг эхлүүлэх нөхцөл бүрдэх юм. | 40 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 57 | 2.72.Дархан, Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолбор байгуулах нөхцөлийг бүрдүүлнэ. | 3. Төмөртэйн уурхайд хуурай болон нойтон соронзон баяжуулах үйлдвэр байгуулах | 2017 - 2018 | УУХҮЯ /ХҮГТБХЗГ/ | | Үйлдвэр ашиглалтад орох | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны 06-р сарын 03-ны өдрийн А/136 тоот тушаалаар байгуулагдсан "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл хэрэгжүүлэх концессын гэрээ"-ний хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг нь батлагдсан удирдамжийн дагуу 2019 оны 06 дугаар сарын 17-ны өдрөөс 2019 оны 06 дугаар сарын 20-ны өдрүүдэд "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн гангийн үйлдвэр болон уурхай, баяжуулах үйлдвэр, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлууд болон үйл ажиллагаатай танилцсан ба улмаар дүгнэлт гарган цаашид авах арга хэмжээний талаар урдьчилсан байдлаар дүгнэлт, санал боловсруулсан. Үүнд: Концессын гэрээний концессын зүйлийн хэсгүүд /2.1.1-2.1.6/-ийн хэрэгжилт 75 хувьтай, гэрээний 2 дугаар бүлгийн 2.1.2, 2.1.3 дах хэсгүүд болох төмөртэйн уурхай дээр нойтон баяжуулах үйлдвэр байгуулах, шууд ангижруулсан төмрийн үйлдвэр байгуулах, гангийн үйлдвэрийн өргөтгөл хийх ажлууд хугацаандаа хэрэгжээгүй байна. Иймээс гэрээний хугацаандаа хэрэгжээгүй концессын зүйлийн хэрэгжүүлэх хугацааг сунгах болон бусад хувилбарыг судалж байна. | 40 |
| 58 | | 4. Шууд ангижруулсан төмрийн үйлдвэр байгуулах | 2018 - 2020 | УУХҮЯ /ХҮГТБХЗГ/ | | Үйлдвэрийн барилгын ажил эхлэх | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны 06-р сарын 03-ны өдрийн А/136 тоот тушаалаар байгуулагдсан "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл хэрэгжүүлэх концессын гэрээ"-ний хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг нь батлагдсан удирдамжийн дагуу 2019 оны 06 дугаар сарын 17-ны өдрөөс 2019 оны 06 дугаар сарын 20-ны өдрүүдэд "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн гангийн үйлдвэр болон уурхай, баяжуулах үйлдвэр, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлууд болон үйл ажиллагаатай танилцсан ба улмаар дүгнэлт гарган цаашид авах арга хэмжээний талаар урдьчилсан байдлаар дүгнэлт, санал боловсруулсан. Үүнд: Концессын гэрээний концессын зүйлийн хэсгүүд /2.1.1-2.1.6/-ийн хэрэгжилт 75 хувьтай, гэрээний 2 дугаар бүлгийн 2.1.2, 2.1.3 дах хэсгүүд болох төмөртэйн уурхай дээр нойтон баяжуулах үйлдвэр байгуулах, шууд ангижруулсан төмрийн үйлдвэр байгуулах, гангийн үйлдвэрийн өргөтгөл хийх ажлууд хугацаандаа хэрэгжээгүй байна. Иймээс гэрээний хугацаандаа хэрэгжээгүй концессын зүйлийн хэрэгжүүлэх хугацааг сунгах болон бусад хувилбарыг судалж байна. | 40 |
| 59 | | 5. Гангийн үйлдвэрийн өргөтгөл хийж, хүчин чадлыг нь нэмэгдүүлэх | 2019 - 2020 | УУХҮЯ /ХҮГТБХЗГ/ | | | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны 06-р сарын 03-ны өдрийн А/136 тоот тушаалаар байгуулагдсан "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл хэрэгжүүлэх концессын гэрээ"-ний хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг нь батлагдсан удирдамжийн дагуу 2019 оны 06 дугаар сарын 17-ны өдрөөс 2019 оны 06 дугаар сарын 20-ны өдрүүдэд "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн гангийн үйлдвэр болон уурхай, баяжуулах үйлдвэр, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлууд болон үйл ажиллагаатай танилцсан ба улмаар дүгнэлт гарган цаашид авах арга хэмжээний талаар урдьчилсан байдлаар дүгнэлт, санал боловсруулсан. Үүнд: Концессын гэрээний концессын зүйлийн хэсгүүд /2.1.1-2.1.6/-ийн хэрэгжилт 75 хувьтай, гэрээний 2 дугаар бүлгийн 2.1.2, 2.1.3 дах хэсгүүд болох төмөртэйн уурхай дээр нойтон баяжуулах үйлдвэр байгуулах, шууд ангижруулсан төмрийн үйлдвэр байгуулах, гангийн үйлдвэрийн өргөтгөл хийх ажлууд хугацаандаа хэрэгжээгүй байна. Иймээс гэрээний хугацаандаа хэрэгжээгүй концессын зүйлийн хэрэгжүүлэх хугацааг сунгах болон бусад хувилбарыг судалж байна. | 40 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 60 | | үйлдвэрлэлийн бизнесийн таатай орчныг бүрдүүлж, төмөрлөгийн үйлдвэрүүдийн ашиглалтыг сайжруулах, импортын хэмжээг бууруулах | 2017 - 2020 | УУХҮЯ /ХҮГТБХЗГ/ | | Төр, хувийн хэвшлийн түншлэл 100,000.0 Төмөрлөгийн үйлдвэрүүдийн ашиглалт сайжирч, барилгын салбар | "Бэрзн групп" ХХК нь Орхон аймагт жилд 200 мянган тонн ган хайлах хүчин чадалтай үйлдвэрийг 2020 онд ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Тоног төхөөрөмжийн угсралтын ажлууд хийгдэж, туршилт-зүгшрүүлэлтийн ажлууд хийгдэж байна. Үйлдвэр ашиглалтад орсноор дотоодын гол нэр төрлийн ган бүтээгдэхүүний хэрэглээний 50 хүртэл хувийг хангах боломжтой болох юм.Үйлдвэрийн эргэлтийн хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр барилга хот байгуулалтын яамтай хамтран ажиллаж байна. Мөн БХБЯ-ны Сайдын 2020 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 94 дугаар тушаалаар байгуулагдсан Арматур үйлдвэрлэгч, импортлогч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаатай танилцаж, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж байна. | 70 |
| 61 | 2.73.Нүүрс угаах, гүн боловсруулах үйлдвэр болон нүүрсний нийлэг хийн үйлдвэр байгуулахыг бодлогоор дэмжинэ. | 5. Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэрийн нарийвчилсан ТЭЗҮ, барилгын зураг төсөл боловсруулах, барилгын ажлыг гүйцэтгэж, үйлдвэрийг хүлээн авч ашиглалтад оруулах | 2018 - 2020 | УУХҮЯ /ХҮГТБХЗГ/ | Барилгын ажил э | | МУ-ын ЗГ-ын 2016.09.28-ны өдрийн 107 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд УУХҮС-ын 2016 оны А/43 дугаар тушаалаар УУХҮЯ-ны дэргэд "Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр барих" төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулан ажиллаж, төслийн НТЭЗҮ болон БОННҮ, БНБОҮ-ний тайлангуудыг хүлээн авсан.<br>Засгийн газрын 2019 оны 451 дугаар тогтоолоор тус төслийн нэгжийг татан буулгаж чиг үүрэг, холбогдох баримт бичгийг "Эрдэнэс Монгол" ХХК-д шилжүүлэхийг УУХҮ-ийн сайдад даалгасны дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/02 дугаар тушаалаар "Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр барих төсөл хэрэгжүүлэх нэгж"-ийг татан буулгаж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/06 дугаар тушаалаар байгуулагдсан Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон "Эрдэнэс Монгол" ХХК-ийн төлөөлөл бүхий Ажлын хэсгийн 2020.02.04-ны өдрийн актаар татан буугдсан төслийн нэгжийн чиг үүрэг, холбогдох баримт бичгийг ЗГХЭГ-ын харьяа "Эрдэнэс Монгол" ХХК-д шилжүүлээд байна. | 40 |
| 62 | 2.74.Шингэрүүлсэн түлш, шатах тослох материалын үйлдвэр байгуулах ажлыг бодлогоор дэмжинэ. | 1. Улаанбаатар хотод жилд 15,000 тн тос, тосолгооны материал үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр байгуулахыг дэмжих | 2016 - 2019 | УУХҮЯ /ХҮГТБХЗГ/ | | Үйлдвэрийн барилгын ажлыг гүйцэтгэх | "Тос, тосолгооны материалын эрэлт, нийлүүлэлт, үйлдвэрлэл, технологи"-ийн чиглэлээр урьдчилсан судалгааны материалыг бэлдэж удирдлагад танилцуулсны дагуу холбогдох дэлгэрэнгүй судалгааны ажлыг мэргэжлийн судалгааны байгууллагаар гүйцэтгүүлэхээр шийдвэрлэн, түүнд шаардагдах зардлыг УУХҮЯ-ны 2019 оны Эрдэм шинжилгээний, судалгааны ажлын төсөвт суулгаад байна. Мөн "Интер стандарт нефть" ХХК-ийн тос тосолгооны материал үйлдвэрлэх төслийг дэмжиж Төслийн нийт хөрөнгө оруулалтын 20%-ийг Хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр урьдчилсан байдлаар тус банктай тохиролцож, саналыг бичгээр хүргүүлээд байна. | 40 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 63 | 2.75.Метал хийц, угсралтын үйлдвэрийг хөгжүүлнэ. | 1. Автомашин, хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж, машин механизм угсрах, автомашины эд анги үйлдвэрлэх үйлдвэр, технологийн парк байгуулахыг дэмжих | 2017 - 2020 | УУХҮЯ /ХҮГТБХЗГ/ | | Үйлдвэр, технологийн парк байгуулах судалгааны ажлууд хийгдэх | “Автомашин, машин механизм угсрах, автомашины эд анги үйлдвэрлэх үйлдвэрлэл, технологийн парк байгуулах боломж нөхцөл” сэдэвт зөвлөх үйлчилгээний Үнэлгээний хороо 2018.04.24-ний өдөр хуралдаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан бөгөөд гүйцэтгэгчээр шалгарсан ШУТИС-ийн Механик, тээврийн сургуультай 2018.05.17-ны өдөр зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан ажиллаж судалгааны ажлын эцсийн тайланг 2018.12.13-ны өдөр хүлээн авсан ба Орхон аймаг нь Хангайн бүсийн тулгуур төв бөгөөд Улаанбаатар, Дархан хотуудтай авто зам болон төмөр замаар холбогдож, цахилгаан эрчим хүч, усан хангамж, хүний нөөц зэрэг дэд бүтэц бүрдсэн иймээс “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг түшиглэн үйлдвэрлэл, технологийн паркийг тус үйлдвэрийн үйлдвэрлэлийн бүсийн зүүн урд талд төлөвлөсөн нь эдийн засгийн хувьд үр ашигтай, зардал багатай байх нь судалгаагаар харагдсан ба “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын захиалгаар"ЭС АЙ СИ ЭЙ" ХХК нь 2018 оны 07 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан 6/015-18 дугаар гэрээний дагуу "Засвар механикийн заводод 2018-2031 онуудад хийгдэх өргөтгөл шинэтгэлийн Техник эдийн засгийн үндэслэл боловсруулах" зөвлөх үйлчилгээний ажлыг гүйцэтгэж 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдөр хүлээлгэн өгсөн. Тус ТЭЗҮ-г 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Эрдэс баялаг мэргэжлийн зөвлөлийн Хүнд үйлдвэрийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдсэн. Одоогоор “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Засвар механикийн заводын Цутгуурын цехийн хэвний технологи бүрэн шинэчлэгдэж 2020 оны 06 дугаар сард үйлдвэрлэлийг туршилтаар эхлүүлээд байна. | 70 |
| 64 | 2.92.Цэвэрлэх байгууламжаар цэвэрлэсэн ус болон хөрсний усыг үйлдвэрийн технологийн хэрэгцээнд ашиглах боломжийг бүрдүүлнэ. | 2. Хөрсний усыг үйлдвэрийн технологийн хэрэгцээнд ашиглах чиглэлээр судалгаа хийх | 2017 - 2018 | БХБЯ | | Судалгааны үр дүнг хэлэлцүүлэх | ШУТИС-ын дэргэдэх Усны судалгааны төвөөс Хөрсний усыг үйлдвэрийн хэрэгцээнд ашиглах, энэ чиглэлээр судалгаа хийхэд шаардагдах төсөв, хөрсний усыг ашиглах төслийн саналыг үндсэн хэрэгжүүлэгч БХБЯ-нд ирүүлсэн ба асуудлыг судалж байна. | /-/ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 65 | 2.99.Шивээ-Овоо, Тэвшийн говь болон бусад нүүрсний ордыг түшиглэн экспортын зориулалттай том чадлын цахилгаан станц, тогтмол гүйдлийн цахилгаан дамжуулах шугам барих төслийг эхлүүлнэ. | 5. Хашаат цав, Тэвшийн говийн орд газруудыг түшиглэн том чадлын цахилгаан станц, тогтмол гүйдлийн цахилгаан дамжуулах шугам, нүүрсний уурхай байгуулах төслүүдийг эхлүүлэх | 2018 - 2020 | ЭХЯ | | Төслийн суурь судалгааны ажилд дэмжлэг үзүүлэх | Тэвшийн говийн нүүрсний ордыг түшиглэн цахилгаан станц байгуулахаар концессын гэрээ байгуулагдсан ба Үндэсний хөгжлийн газар хариуцан ажиллаж байна. | /-/ |
| ГУРАВ. НИЙГМИЙН БОДЛОГО | | | | | | | | |
| 66 | 3.2.33.Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарт олон улсын жишигт нийцсэн барилга, байгууламж, лабораторын орчин нөхцөл бүхий дэд бүтцийг бий болгохыг дэмжинэ. | 10. Уул уурхай, шинжлэх ухааны чиглэлд бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх хүрээнд Шинжлэх ухаан, танин мэдэхүйн мэдээллийн төв байгуулах барилга, байгууламжийн асуудлыг шийдвэрлэх | 2018 | ЦЭК | | Шинжлэх ухаан, танин мэдэхүйн мэдээллийн төвийн байрны асуудлыг шийдвэрлүүлэх, ТЭЗҮ-ийг батлуулах | Толгойлон хэрэгжүүлэгч ЦЭКАА-аас биелэлт гарна. | /-/ |
| Дөрөв. БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 67 | 4.1.3.Байгаль орчны багц хуулийг хэрэгжүүлэх цогц арга хэмжээ авч, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй үйлдвэрлэл, үйлчилгээ болон байгалийн нөөцийн хууль бус ашиглалтад тавих хяналтыг сайжруулна. | 1. Байгаль орчны үнэлгээ, аудитаар дамжуулан ашиглагч нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэх | 2016 - 2020 | БОАЖЯ | | 200-250 төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянан баталж, хэрэгжилтийг хангуулах | БОАЖЯ-ны Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний Мэргэжлийн зөвлөлийн хуралд яамны төлөөллийг оролцуулж, 2019 оны 6 дугаар сарын байдлаар уул уурхай, дэд бүтэц, үйлдвэр, аялал жуулчлалын төслүүдийн нийт 237 байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянан батлаж үйл ажиллагааг нь явуулж байна.. | 100 |
| 68 | 4.2.3.Усны нөөцийг хамгаалж, хомсдолоос сэргийлэх нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, хаягдал бохир усыг цэвэрлэн дахин ашиглах технологи нэвтрүүлэхийг дэмжинэ. | 2. Ус ашиглалтыг бүрэн тоолууржуулж, хаягдал бохир усыг цэвэрлэж, дахин ашиглалтыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах | 2017 - 2020 | БОАЖЯ | | 200-250 төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянан баталж, хэрэгжилтийг хангуулах | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын А/14 дүгээр тушаалаар байгуулагдсан Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2019 онд хэлэлцсэн 171, 2020 оны эхний хагас жилийн байдлаар 89 техник, эдийн засгийн үндэслэл хэлэлцсэн ба уурхай, уулын үйлдвэрт хэрэглэгдэх усыг эргүүлэн ашиглаж байгаа талаар хяналт тавьж ажиллав. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 69 | 4.2.6.Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах бодлого хэрэгжүүлж, уул уурхайн хайгуул, олборлолтод өртөж, эвдрэлд орсон газар нутгийг нөхөн сэргээнэ. | 1. Уул уурхайн улмаас эвдэрсэн газрын хохирлыг тооцох, нөхөн сэргээх эрх зүйн зохицуулалтыг бий болгох, нөхөн сэргээлт хийх | 2016 - 2020 | БОАЖЯ | | Уул уурхайн улмаас эвдэрсэн газрын хохирлыг тооцох, нөхөн сэргээх эрх зүйн орчныг бүрдүүлэх | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын А/85 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг нийт 21 аймагт бүсчилсэн 10 чиглэлд орон нутагт томилолтоор ажиллаж, орон нутгийн удирдлага, аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй уулзалт хийж, чиглэл хүргүүлсэн. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны А/90 тоот тушаалаар Орон нутгийн хөндөгдсөн газарт нөхөн сэргээлт хийлгэхтэй холбоотой үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Мөн БОАЖС-д хамтарсан ажлын хэсэг байгуулж ажиллах санал хүргүүлсэн. БОАЖЯ-аас 2018 оны 10 дугаар сарын 22-23-ний өдрүүдэд зохион байгуулсан, “Байгаль хамгаалал ба уул уурхайн нөхөн сэргээлт” үндэсний сургалт, семинарт АМГТГ-ын төлөөлөл оролцож, нөхөн сэргээлтийн хуулийн төсөл, байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянах, хүлээн авах журамд орох өөрчлөлтийн төслийг танилцуулан хэлэлцсэн. Мөн MIRECO төслийн хүрээнд дээрх хуулийн төсөлд холбогдох саналыг өгсөн. Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгад уул уурхайн нөхөн сэргээлтийн үндсэн суурь харилцааг зохицуулах, холбогдох хуулийн төслүүдийн үзэл баримтлал хуулийн төслүүдийн уялдаа холбоог хангах, байгаль орчны хохирол тооцох асуудлыг цогц байдлаар шийдвэрлэх талаар санал тайлбар хүргүүлсэн.<br>БОАЖС-ын 2018.03.13-ны өдрийн А/59 дүгээр тушаалаар байгуулагдсан “Нөхөн сэргээлтийн тухай” хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. Уг ажлын хэсэгт тус яамны төлөөлөл оролцон ажилласан бөгөөд хуулийн төсөл, хуулийн үзэл баримтлалын төслийг тус тус боловсруулан “Хууль тогтоомжийн тухай хууль”-ийн дагуу “Хуулийн төслийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах”, “Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх”, “Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцооны судалгаа” тус бүрийг хийлгүүлж, тайланг хүлээж авч, саналыг хуулийн төсөлд тусгасан. Хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг батлуулахаар БОЯЖЯ-ны 2018.09.13-ны 01/6369 дугаар албан бичгээр ХЗДХЯ-нд хүргүүлсэн. ХЗДХЯ-аас БОАЯЖ-нд 2018.10.08-ны өдрийн 1-1/4867 дугаар албан бичгээр уул уурхайн нөхөн сэргээлтийн үндсэн суурь харилцааг зохицуулсан газар, түүнтэй холбоотой хуулийн төслүүдийн үзэл баримтлал тодорхой болсоны дараа тэдгээрт нийцүүлэх, дээрх хуулийн төслүүдийн уялдаа холбоог хангах, байгаль орчны хохирол тооцох асуудлыг цогц байдлаар шийдвэрлэхээр болсон гэсэн үндэслэлээр үзэл баримтлалын төслийг буцаасан.<br>Улмаар тус яаманд БОАЖЯ-наас хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг батлуулах тухай 2019.10.07-ны өдрийн 01/6912 тоот албан бичгийг ирүүлсэн бөгөөд тус яамнаас холбогдох саналыг 2019.11.20-ны өдрийн 01/3230 тоот албан бичгээр БОАЖЯ-нд хүргүүлсэн. | 100 |
| 70 | | 3. Аж ахуйн нэгж, мэргэжлийн байгууллагын үүрэг, хариуцлагыг өндөржүүлэх, чадавхийг бэхжүүлэх замаар нөхөн сэргээлтийн | 2017 - 2020 | БОАЖЯ | | Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй ААН, газрын хэвлийн нөхөн сэргээлтийн | 2018 онд 1059.3 га талбай уулын ажилд өртөж, техникийн нөхөн сэргээлтийг 753.0 га талбайд, биологийн нөхөн сэргээлтийг 697.5 га талбайд хийсэн бол 2019 онд 467.3 га талбай уулын ажилд хамрагдсан бөгөөд нөхөн сэргээлтэд зарцуулсан зардал 11.24 тэрбум төгрөг хүрч техникийн нөхөн сэргээлтийг 542.7 га талбайд, биологийн нөхөн сэргээлтийг 371.4 га талбайд хийсэн байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 71 | 4. Уул уурхайн сөрөг нөлөөллийг бууруулах дэд хөтөлбөр хэрэгжүүлж, холбогдох стандартуудыг шинэчлэх, сургалт, судалгааны төв байгуулах | 2016 - 2020 | БОАЖЯ, МХЕГ | | Уул уурхайн сөрөг нөлөөллийг бууруулах дэд хөтөлбөрийг батлуулж, холбогдох стандартыг шинэчлэх, аргачлал боловсруулж эхлэх | Үндсэн хэрэгжүүлэгч БОАЖЯ болон БНСУ-ын Уул уурхайн Нөхөн Сэргээлтийн Корпораци (MIRECO) хамтран БНСУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлж буй "Монгол улсад Уул уурхайн сөрөг нөлөөллийг бууруулах менежментийн чадавхийг бэхжүүлэх" төслийн Мастер төлөвлөгөө боловсруулах багт яамны төлөөлөл оролцож холбогдох санал өгч ажилласан. Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журмын төсөл, нөлөөллийн шинжилгээний тайлан боловсруулж, батлуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018.04.24-ний өдрийн А/88 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн хүрээнд "Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам"-ын төслийг боловсруулахаар удаа дараа вакум орчинд ажиллан төслийг боловсруулж дуусгасан. Энэ хугацаанд Ажлын хэсгийн хурлыг тогтмол зохион байгуулж мөн СЕСМИМ төслийн хүрээнд зохион байгуулсан Канад улсын Бритиш Колумб мужын Эрчим хүч, уул уурхай, газрын тосны нөөцийн яамны төлөөлөгчдтэй цуврал уулзалт, семинар, сургалтад оролцож санал, бодлоо солилцож "Бритиш Колумб мужийн Байгаль орчны нөхөн сэргээлтийн баталгаа, эрх зүйн зохицуулалт, туршлага" сэдэвт семинарын хүрээнд туршлага судлан ажилласан. Журмын төслийг эцэслэн боловсруулж, УУХҮС, БОАЖС нарын 2019 оны А/181/А/458 дугаар тушаалаар батлуулж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2019.11.21-ний өдрийн 4530 дугаарт бүртгүүлсэн. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 72 | | 5. Орхон, Туул гол болон бусад голуудын хамгаалалтын бүсэд ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа явуулж буй ААН-ийг хууль тогтоомжид нийцүүлэх арга хэмжээ авах, хариуцлагатай уул уурхайн зарчмыг мөрдүүлж усны бохирдлыг бууруулах | 2016 - 2019 | БОАЖЯ | | Хамгаалалтын бүсэд явуулж байгаа үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах | Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт Ашигт малтмал, газрын тосны газрын төлөөлөл орж ажилласан бөгөөд шаардлагатай мэдээ, мэдээллээр хангаж ажилласан. Ажлын хэсэг нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж, хуулийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийг технологийн горимын дагуу үйл ажиллагаа явуулах талаар чиглэл, зөвлөмж өгч ажилласан бөгөөд энэ тухай саналыг ажлын хэсэгт хүргүүлсэн. “Орхон голын эхэнд буюу Архангай аймгийн Цэнхэр суманд үйл ажиллагаа явуулж буй уул уурхай эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд нь хяналт тавих зорилгоор 2016 оноос хойш жил бүр 4-10 дугаар сарын хооронд орон нутгийн хяналтын байгууллага болох Архангай аймгийн МХГ, БОАЖГ, Орхон голын сав газрын захиргаанаас төлөөллүүд газар дээр нь ажиллаж байнга хяналт тавьж байна. 2016 онд Нийслэлийн ИХТ-ын 50-р тогтоолоор Туул голын хамгаалалтын бүсийг шинээр тогтоосон. Дээрх бүсэд хамрагдсан уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн тусгай зөвшөөрлийг цуцалсан ба шинээр олгохгүй байхаар шийдвэрлэсэн. БОАЖС-ын 2017.03.09-ний өдрийн А/54 тоот тушаалаар Нийслэлийн нутаг дэвсгэр дэх Туул голын хамгаалалтын бүсэд газар ашиглаж байгаа болон түгээмэл тархацтай ашигт малтмал ашигшлаж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын газар ашиглалтыг судалгааг хийх зохих арга хэмжээ авах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан.<br>Энэхүү ажлын хэсгийн хүрээнд Нийслэлийн БОАЖГ болон Нийслэлийн МХГ хоёр хамтран хяналт шалгалтын ажил зохион байгуулан ажилласан. Үүний дагуу Нийслэлийн Засаг даргын захирамжийн 2017.08.21-ний А/609 тоот тушаалаар Туул голын хамгаалалтын бүсэд хамрагдсан уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй 62 аж ахуйн нэгжүүдийн тусгай зөвшөөрлийг цуцалсан ба шинээр олгохгүй байхаар шийдвэрлэсэн.<br>Түүнчлэн 2019 онд Орхон голын голдиролыг дагасан Архангай аймгийн нутаг ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байсан 13 тусгай зөвшөөрлийг Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас гаргасан дүгнэлтийн дагуу Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн даргын шийдвэрээр хүчингүй болгосон. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 73 | 4.2.6.Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах бодлого хэрэгжүүлж, уул уурхайн хайгуул, олборлолтод өртөж, эвдрэлд орсон газар нутгийг нөхөн сэргээнэ. | 6. Баруун бүсэд дүйцүүлэн хамгааллын жишиг төсөл хэрэгжүүлэх | 2016 - 2019 | БОАЖЯ | | Баян-Айраг, Хотгор, Хөшөөтийн орд газрын биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгааллын жишиг хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэх | Үндсэн хэрэгжүүлэгч БОАЖЯ-наас Даян дэлхийн байгаль хамгаалах сан /GEF/ НҮБХХ-ийн буцалтгүй тусламжтайгаар хэрэгжүүлж уй, Монгол орны баруун бүсэд хөгжлийн сөрөг нөлөөлөл, газрын доройтлыг бууруулах үе шат, дүйцүүлэн хамгааллыг ландшафтын түвшний төлөвлөлт, менежментэд нэвтрүүлэх замаар уул уурхайгаас бэлчээрт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилготой "Монгол орны баруун бүс нутгийн газрын доройтол, хөгжлийн сөрөг нөлөөллийг бууруулах, дүйцүүлэн хамгааллыг нэвтрүүлэх" төслийн Удирдах хороонд яамны төлөөлөл ажиллаж байна. Удирдах хорооны 2 дугаар хуралдаанд оролцсон. Төслийн хүрээнд Баян-Айраг, Хөшөөтийн уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулсан хохирлыг тооцож, дүйцүүлэн хамгааллын арга хэмжээнд төлөвлөсөн арга хэмжээ, түүний зардалд үнэлэлт, дүгнэлт өгөх, газрын доройтлыг бууруулах дүйцүүлэн хамгаалах цаашдын арга хэмжээний цар хүрээг тодорхойлон улмаар орон нутагт чадавхижуулах сургалтыг удаа дараа зохион байгуулан холбогдох уурхайнуудын биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгааллын хөтөлбөрийн төслийг хэлэлцэн, эцэслэн боловсруулж уул уурхайн аж ахуйн нэгжид хүлээлгэн өгсөн байна. Төслийн үйл ажиллагааны хаалтын хурал нь 2019.05.19-ний өдөр зохион байгуулсан болно. | 100 |

Хянасан:
ХШҮДАГ-ын дарга Г.Ганхүү

ХШҮДАГ-ын шинжээч Б.Баяржаргал

Үнэлгээ хийж дүгнэлт зөвлөмж гаргасан:

ХШҮДАГ-ын мэргэжилтэн Д.Батнайрамдал

Тайлан нэгтгэсэн:
ТЗУГ-ын ахлах мэргэжилтэн Г.Мөнгөнзул